

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН
/ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛЫН ГҮЙЦЭТГЭХ/
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот

2019 он

Судалгааны захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааны багийн ахлагч:

Б.Галбадрах

Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч,
Хууль зүйн доктор /Ph.D/

Судалгааны багийн гишүүд

Б.Алтангэрэл

Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын
төвийн эрхлэгч,
Хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор

Г.Хосбаяр

Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын
тэнхимийн ахлах багш, Хууль зүйн магистр

Э.Өнөболд

Мөн тэнхимийн багш, Хууль зүйн магистр

Судалгааг хянасан:

Б.Батболд

Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
захирал, Удирдахуйн ухааны магистр

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт

Зураг, хүснэгтийн жагсаалт

Нэр томъёоны тайлбар

Хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн жагсаалт

Ерөнхий мэдээлэл

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. Дүгнэлт

4.2. Зөвлөмж

ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

ХАВСРАЛТ

Товчилсон үгийн жагсаалт:

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
УДШ	Улсын Дээд Шүүх
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЯЭА	Хорих ял эдлүүлэх алба
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ХАДЖ	Хорих ангийн дотоод журам

Зураг, хүснэгтийн жагсаалт:

Зураг 1.	Дэлхийн улс орнуудын хоригдлын тоон судалгаа 2018 он
Зураг 2.	2003-2019 оны жилийн эцсийн байдлаар хорих ял эдэлсэн хоригдлын тоон үзүүлэлт
Зураг 3.	Хорих байгууллагын тогтолцооны схем
Зураг 4.	Нээлттэй хорих ангийн зэрэглэл
Зураг 5.	Хаалттай хорих ангийн зэрэглэл
Зураг 6.	Эмэгтэйчүүдэд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх тогтолцоо
Зураг 7.	2003-2016 оны хооронд гянданд ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт
Зураг 8.	2003-2016 оны хооронд онцгой дэглэмтэй хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт
Зураг 9.	2003-2016 оны хооронд онцгой дэглэмтэй хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт
Зураг 10.	2003-2016 оны хооронд жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт
Зураг 11.	2003-2019 оны хооронд эмэгтэйчүүдийн хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт
Зураг 12.	2003-2019 оны хооронд насанд хүрээгүйчүүдийн хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт
Зураг 13.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /2017 оны үйлчлэлийн хүрээнд нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлсэн хоригдлын судалгаа
Зураг 14.	Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн үзүүлэлт
Зураг 15.	Судалгаанд оролцогчдийн насны байдал
Зураг 16.	Судалгаанд оролцогчдийн боловсролын судалгаа
Зураг 17.	Судалгаанд оролцогчдийн мэргэжилтэй эсэх судалгаа
Зураг 18.	Судалгаанд оролцогчдийн мэргэжлийн судалгаа
Зураг 19.	Судалгаанд оролцогчдийн ажил, хөдөлмөр эрхэлж байсан эсэх судалгаа
Зураг 20.	Судалгаанд оролцогчдийн гэр бүлийн судалгаа
Зураг 21.	Судалгаанд оролцогчдийн урьд гэмт хэрэг үйлдэж байсан эсэх судалгаа
Зураг 22.	Судалгаанд оролцогчдийн хорих ангид ял эдэлсэн хугацааны судалгаа
Зураг 23.	Судалгаанд оролцогчдийн уулзалт авдаг эсэх судалгаа
Зураг 24.	Судалгаанд оролцогчдийн сургалтын хэрэгцээний судалгаа
Зураг 25.	Сургалтын хэлбэрийн судалгаа
Зураг 26.	Суллагдсаны дараа хийх зүйлийн судалгаа
Зураг 27.	2012-2018 оны хооронд бүрэн дунд боловсрол олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт
Зураг 28.	2012-2018 оны хооронд бичиг үсгийн сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт
Зураг 29.	2012-2018 оны хооронд мэргэжлийн дадлага олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт
Зураг 30.	2012-2018 оны хооронд дээд боловсрол олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт
Хүснэгт 1.	Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт
Хүснэгт 2.	2002, 2015 оны Эрүүгийн хуульд туссан хорих ял, түүнийг эдлүүлэхтэй холбоотой хэм хэмжээний харьцуулалт
Хүснэгт 3.	2002, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд туссан хорих дэглэм, зэрэглэлийн ялгаанд хийсэн харьцуулалт

- Хүснэгт 4. Дээрх хоёр хуулийн хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын дүн шинжилгээ хийж үзвэл:
- Хүснэгт 5. 2002, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нийгэмшүүлэх ажлын талаар туссан байдал
- Хүснэгт 6. Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын зохицуулалт

Нэр томъёоны тайлбар

(Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах зарим нэр томъёог тайлбарлав)

1.	Аюулгүй байдал дотоод, гадаад шинж чанартай аливаа аюул заналхийллээс иргэн, олон нийт, байгууллага, төрийн ашиг сонирхол хамгаалагдсан байдал.
2.	Албадан эмчлэх сэтгэцийн болон согтуурах мансуурах донтой, халдварт өвчтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэх ажиллагаа.
3.	Биечилсэн хяналт, хамгаалалт хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төрөл бөгөөд алба хаагчдын хүчээр гүйцэтгэнэ.
4.	Гэмт хэрэг Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй.
5.	Дэглэм хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үүсч бий болсон эрхийн хязгаарлалт, ял эдлүүлэх нөхцөл, журам, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон өөр хоорондоо ялгаа, өвөрмөц байдал бүхий үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээний нийлбэр юм.
6.	Дулаан, хөдөлгөөн мэдрэх дохиолол гадны биетийн дулаан, хөдөлгөөн мэдрэгдсэн тохиолдолд дуут дохио өгөх цахим дохиоллын төхөөрөмж.
7.	Дүрс бичлэгийн хяналт бүхий зурвас телекамерийн хяналттай бүс.
8.	Мэргэжлийн боловсрол, сургалтад хамруулах тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагаа.
9.	Мэргэжлийн дадлага олгох ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын үйл явц.
10.	Нээлттэй, хаалттай хорих анги хорих ял эдлүүлэх дэглэмийн төрөл.
11.	Нээлттэй, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэл хорих ял эдлүүлэх дэглэмийн ангилал
12.	Нээлттэй, хаалттай хорих ангийн тусгай зэрэглэл хорих ял эдлүүлэх дэглэмийн ангилал
13.	Нэгжлэг хүний бие, хувцас, хэрэглэл, байр орчинд хориглосон эд зүйл байгаа гэх сэжиг, таамаг бий болсон, эсвэл гэмт хэрэг, зөрчил үйлдэхдээ ашигласан, ашиглахаар төлөвлөсөн эд зүйл, түүний улмаас үүссэн ул мөрийг илрүүлэх зорилгоор эд зүйлийн угсралтыг бүрэлдэхүүн хэсгээр задалж үзэх зэргээр нарийвчлан хийж буй шалган баримтжуулах ажиллагаа.
14.	Нийгэмшүүлэх ажил хоригдлыг хорих байгууллагад хүлээн авахаас эхлэн ял эдлэх бүхий л хугацааг хамран, суллахад бэлтгэх, сулласны дараах үйл явцаар дуусгавар болдог сэтгэл

	зүй, сурган хүмүүжүүлэх, анагаах, хууль зүй, нийгэм, эдийн засгийн зохион байгуулалттай нөлөөллийн цогц арга хэмжээ.
15.	Хорих ял
	иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хоригдолд эрхийн хязгаарлалтаар дамжуулан цээрлэл амсуулах, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг төрийн албадлагын онцгой төрөл юм.
16.	Хорих байгууллага
	эрүүгийн ял гүйцэтгэх тогтолцооны төрөлжсөн байгууллага.
17.	Хорих ял эдлүүлэх ажиллагаа
	хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан үйлийг төлөвшүүлэн нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хуулиар эрхийн хязгаарлалт тогтоон, тодорхой дэглэм, журмын хүрээнд аюулгүй байдлыг ханган хорьж буй арга хэмжээ.
18.	Хоригдол
	хорих ял эдэлж байгаа ялтан
19.	Хорих анги
	шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага
20.	Хорих ангийн дарга
	хорих ангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах чиг үүрэг бүхий албан тушаалтан
21.	Хорих ял эдлүүлэх албаны дарга
	хорих ангиудын үйл ажиллагааг нэгдсэн болон мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий албан тушаалтан
22.	Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс
	хүний оюун ухаан, бие бялдрын хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж, тахир дутуу хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас хэсэгчлэн алдсан болон шалтгаан түүний хувь хэмжээ, хугацааг тогтоох мэргэжлийн үйл ажиллагаа.
23.	Сахилгын зөрчил
	мөрдөгдөж буй хууль тогтоомжид сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан үйлдэл.

**ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТУУД**

д/д	Журмын нэр	Дугаар	Баталсан огноо
Нэг. Хууль			
1	Үндсэн хууль		1992-01-13
2	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/		2015-12-03
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/		2017-06-09
4	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/		2017-05-18
5	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай		1999-01-07
6	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/		2017-12-07
7	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай		2014-04-15
8	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай		1994-06-13
9	Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/		2017-05-11
Хоёр. Засгийн газрын тогтоол			
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	204	2017-07-04
2	Хорих байгууллагын албан хаагчдад хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журам	217	2002-10-23
3	Хорих байгууллагын алба хаагчдын ажлын онцгойн нэмэгдэл	189	2011-06-22
4	Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэмийг батлах тухай	204	2017-07-04
5	МУ-ын Засгийн газрын 258-р тогтоол-Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	258	2018-08-22
6	МУ-ын Засгийн газрын 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 01 албан даалгавар - Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	01	2017-10-26
Гурав. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал			
1	Хуулийн байгууллагын ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай	87/111/ 118	2011-06-23
2	Баривчлах шийдвэр биелүүлэх журам	A/227	2014-12-08
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг өргөх ёслолын журам	A/194	2017-07-21
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бэлгэ тэмдэг, тугны загвар, хэрэглэх журам	A/187	2017-07-16
5	Хорих ангийн дотоод журам	A/183	2017-07-04
6	Зөвлөлийн бүрэлдэхүүн үйл ажиллагааны дүрэм батлах тухай	A186 A/74	2017-07-04
7	Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам	A/192 A/81	2017-07-18
8	Хорих ангийн харуул хамгаалалтын журам	A/197	2017-07-25
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх, мэдээллэх журам	A/225 a/101	2017-09-06

10	Галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураан авч хадгалах, устгах, шилжүүлэх журам	A/233 A/100	2017-09-07
11	Хоригдлыг ял эдлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ангийг солих тухай санал гаргах журам	A/235 A/105	2017-09-07
12	Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам	A/236 A/104	2017-09-07
13	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам	A/260 A/112	2017-10-18
14	Хууль зүй, дотоод хэргийн сайдын шагналын журам	A/87	2017-04-13
15	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам	A/73	2017-04-04
16	Жишиг норматив шинэчлэн батлах тухай	A/247	2017-09-29
17	ШШГБ-д ажиллаж буй цэргийн жинхэнэ алба хаагаагүй цэргийн насны алба хаагчдад цэргийн бэлтгэл эзэмшүүлэх хөтөлбөр батлах тухай	A/448	2017-10-20
18	Хоригдлын нормын хувцас, ахуйн хэрэглэлийн нэр төрөл, тоо, эдэлгээний хугацааг тооцох журам	A/18	2018-02-01
19	ШШГБ-ын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам	A/29	2018-02-15
20	Нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн эмнэлгийн дэглэм	A/127 A/69	2018-06-29
21	Хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх журам	A/130	2018-07-30
22	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилга, ёс зүйн дүрэм /Шинэчилсэн/	A/183	2018-09-27
23	Хоригдлыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэгт, шилжүүлэн эмчлүүлэх журам	A/2141 A/462	2018-11-19
24	Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дугаар хамтарсан тушаал “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам”	A/142, A/47	2019-3-29
25	“ШШГБ-ын алба хаагчийн хэрэглэх техник хэрэгсэл, галт зэвсэг, сумыг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журам”	A/52	2019-4-04
26	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын дугаар хамтарсан тушаал “Хүнд өвчтэй хоригдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, “Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалт”	A/152, A/366	2019-07-26
Дөрөв. ШШГЕГ-ын даргын тушаал			
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм	A/32	2008-02-18
2	Нийгмийн ажилтны аргачилсан заавар	A/129	2018-07-03
3	Сэтгэл зүйн ажлын заавар	A/110	2019-06-07
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаны шалгалт явуулах журам	A/34	2013-02-06

5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт	A/81	2013-04-24
6	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам	A/80	2013-04-24
7	ШШГБ-ын үйлчилгээний стандартыг батлах тухай	A/81	2013-04-24
8	ШШГБ-ын хөдөлмөрийн дотоод журам	A/82	2013-04-24
9	ШШГБ-ын ажилтны ёс зүйн дүрэм батлах тухай	A/51	2017-03-10
10	ШШГБ-ын бага бүрэлдэхүүний бодлогын баримт бичиг	A/96	2017-05-03
11	Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах журам	A/169	2017-08-31
12	ШШГБ-ын алба хаагчийн мэргэшлийн түвшин үнэлэх журам	A/178	2017-09-06
13	ШШГБ-ын хүний нөөцийн журам	A/192	2017-09-19
14	ШШГБ-ын алба хаагчийн дүрэмт хувцас, чимэг хэрэглэлийг хураан авах, тооцоо хийх журам	A/194	2017-09-20
15	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам	A/260 A/242	2017-12-14
16	Ахлагчийн зөвлөлийн ажиллах журам	A/167	2018-09-25
17	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлт	A/148	2018-08-31
18	“Хоригдлын өдөр тутмын болон ажлын хувцасны арчилгаа, ариутгал хийх заавар”	A/77	2019-4-22
19	“Сэтгэл зүйн ажлын заавар”	A/110	2019-6-07

Ерөнхий мэдээлэл

Улсын Их Хурлаас 2017 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар иргэний, захиргааны, зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэслэл, журмыг нарийвчлан тогтоож, шүүхийн гүйцэтгэх байгууллагын тогтолцоог шинээр тодорхойлж, тус байгууллагын алба хаагчийн баталгааг улс төрийн, хууль зүйн, эдийн засгийн, нийгмийн болон бусад баталгаа болгон нарийвчлан зааж, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, журмыг тодорхойлсон.

Хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар 2 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна. Гэхдээ эдгээр өөрчлөлтүүд нь зөвхөн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, албадлагын арга хэмжээг хамарсан байгаа юм.

Хорих ял нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хоригдолд эрхийн хязгаарлалтаар дамжсан цээрлэл амсуулах, хоригдлоос дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа зарим тогтворгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг хамгийн өргөн хэрэглэгддэг төрийн албадлагын онцгой төрөл юм. Хүн төрөлхтөн гэмтнийг гэсгээн цээрлүүлэх, хашраах, гэмшүүлэхийн тулд түүнийг шоронд хорихоос өөр илүү дэвшилттэй аргыг өнөө хэр нь олоогүй байгаагийн нэг тод илрэл бол дэлхийн бүх оронд хорих ялыг өргөн хэрэглэсээр ирсэн явдал юм.

Хорих ял нь бусад төрлийн ялтай харьцуулан авч үзвэл:

1/ Хоригдол нь чөлөөтэй зорчин явах эрхээ хязгаарлуулдаг;

2/ Олон нийтээс тодорхой хугацаагаар тусгаарлагддаг;

3/ Харьцангуй удаан хугацаатай;

4/ Тусгай байгууллага болох хорих анги, гянданд хоригддог;

5/ Хоригдол хорих ял эдлэх хугацаандаа нийгэм, хамт олон дотор байж эрх чөлөөт иргэдийн нэгэн адил өөрийн эрх дураар ажиллаж, хөдөлмөрлөх, амьдрах эрхгүй байдаг;

6/ Нийгэм, төрийн үйл ажиллагаанд Үндсэн хуульд заасан улс төрийн эрхээ эдэлж, оролцох боломжоо алддаг;

7/ Гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд, найз нөхдөөсөө хагас тусгаарлагддаг;

8/ Хорих байгууллагын дэглэм, дотоод журамд захирагдах, тэдгээрийг дагаж мөрдөх шаардлагатай болдог;

9/ Иргэн гэхийн оронд хоригдол гэж дуудуулан нэр төрийн хувьд ичгэвтэр байдалд орох зэмлэл хүлээдэг;

10/ Ял шийтгүүлэхийн өмнө ажиллаж, сурч байсан хамт олноосоо тусгаарлагддаг;

11/ Эзэмшсэн мэргэжлийн ажлаа болон дур сонирхолтой, хийхийг хүссэн ажил хөдөлмөр эрхлэх эрхгүй;

12/ Өөрийн мэргэжил, ур чадвар, оюун ухаанаа нийгэмд ашигтай үйл ажиллагаанд зориулах боломжгүй болдог;

13/ Удаан хугацаатай хорих ял шийтгүүлсэн хоригдлын эхнэр, нөхөр гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэл шүүхэд гаргахад маргах эрхгүй болдог;

14/ Хорих ангид ял эдэлж байхдаа хийсэн ажлын хөлсөө өөрөө гардан авах, шууд зарцуулах болон өмч хөрөнгө, эд зүйлээ зориулалтаар зарцуулах, чөлөөтэй ашиглах эрхээ тодорхой хэлбэрээр хязгаарлуулдаг¹.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны онолын зарим асуудал:

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь ялын бодлого, зорилгыг хангахад чиглэх ба ялын бодлого нь тухайн улс орны хөгжлийн шат дахь нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэхэд төрөөс баримталж буй чиглэл бөгөөд төрөөс эрүүгийн ялын бодлогыг хариуцлагын оновчтой төрөл, тогтолцоог бий болгон, оногдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зэрэг арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж байдаг.

Ял нь эрүүгийн эрх зүйн салшгүй институц төдийгүй нийгмийн хамгааллын бодлого, тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Ялыг төрийн бодлогын хүрээнд хэт явцууруулж ойлгох нь эдүгээ ач холбогдлоо алдсан бөгөөд харин нийгмийн шударга ёс, шүүх эрх мэдлийн зарчим, чиг хандлагын хүрээнд авч үзэх хөгжлийн баримтлал болж байна. Эрүүгийн анхны төрөлжсөн хууль /1810 он, Франц/ гарснаас хойшхи шинэ үеийн түүхээс үзэхэд ялын бодлогыг тодорхойлж ирсэн голлох дөрвөн онолын урсгал нэг нь нөгөөгөө үгүйсгэх замаар хөгжиж иржээ.

I үе шат. *Абсолют онол буюу тэнцвэржүүлэх хандлага* (Кант, Гегель) XIX зууны II хагасаас 1950-аад он хүртэл хүчтэй нөлөөтэй хэвээр байсан. Гол агуулга нь “Хохирлыг хохирлоор”, “Гэмтнийг гэсгээлээр” гэсэн үндэслэл, зарчимд тулгуурлан, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрөөс “хашраах” яллан цээрлүүлэх, гэмт хэрэгт нь тохирсон ялыг оноох, шаардлагыг хангахад чиглэгдэж байсан.

II үе шат. *Харьцангуйн онол буюу нийгэмшүүлэх хандлага* (Ж.Руссо, М.Вебер) XX зууны II хагасаас эхлэн абсолют онолыг шүүмжлэх хандлага баруун Европт хүчтэй дэлгэрч, ялын зорилго нь ялтныг нийгмээс тусгаарлаж, залхаан цээрлүүлэхэд гол нь биш, харин эргээд нийгмийн амьдралд хөлөө олоход нь туслах, засч төлөвшүүлэх замаар нийгэмшүүлэхэд чиглэгдэх ёстой гэсэн үзэл баримтлал юм. Энэхүү концепци нь 1960 оноос эхэлсэн ялын бодлогын шинэчлэлд тусгалаа олж, дэлхийн олон орны эрүүгийн хуулиудад илэрч, хэрэгжсэн байна.

III үе шат. *Таслан зогсоох онол буюу “үл тэвчих” хандлага*. 1960 оноос эхэлсэн ялын нийгэмшлийн хандлага зарим талаар шүүмжлэлд өртөх болсны дээр ялангуяа АНУ-д ялын нийгэмшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ ямар ч үр дүнгүй болсныг харгалзан, “гэмт этгээдийг нийгмээс тусгаарлан аюулгүй болгох”, дахин гэмт хэрэг үйлдэхгүй болтол нь “хашраах”, хатуу чанга ял оноох бодлого


¹ Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018 он

баримтлах чиглэл гарч ирэв. Энэхүү хандлага нь ялангуяа АНУ-д түгээмэл дэлгэрч Зүүн Европ, Ойрхи Дорнод, социалист орнуудад ч түгэн тархаж нөлөөлсөн байдаг.

IV үе шат. *Либерал онол буюу дэнслэн хязгаарлах хандлага*. 1990-ээд оны эхэн үеэс эрүүгийн эрх зүйн салбарт гуманизацийн болон криминализацийн үйл явц нэгэн зэрэг өрнөж, глобальчлал болон эрх зүйн интеграцчиллын нөлөөт улс орнуудад түрэн орж ирсэнтэй холбогдон гарч ирсэн бөгөөд уг онолын үндэслэл нь Германы эрүүгийн эрх зүйч-эрдэмтэн Франц Листийн дэвшүүлж байсан гурвалсан шаталбарын онолын үзэл санааг хөгжүүлэх замаар бүрэлдэн тогтжээ². Энэхүү онолоор болгоомжгүй, санамсаргүй тохиолдлоор буюу ялимгүй хэрэг үйлдсэн этгээдэд сануулга өгөх замаар ялаас хэлтрүүлэх, дунд зэргийн хэрэг үйлдсэн буюу их биш бага хэмжээний хохирол учруулсан этгээдэд хүнд биш ял оноох, засарч төлөвших боломж олгох, хүнд ноцтой хэрэг үйлдсэн этгээдийн хувьд засрах боломжтойг нь засч авах, засрах боломжгүйг нь бусдад дахин хор хөнөөл учруулах боломжийг хаах ялын ялгавартай хандах нөхцөлийг олгодог байна³. Түүнчлэн ял нь нэг талаас шийтгэл, нөгөө талаас итгэл хүлээлгэх, засрал төлөвшил олгох нийгмийн арга хэмжээ гэж үзэж, ялын зорилго нь нийгэмшүүлэх болон иргэншүүлэх тал нь давамгайлсан цээрлэл, шийтгэлийн хосолмол систем болох ёстой ажээ⁴.

Дэлхийн улс орнууд сүүлийн үед аль болох хорих ялыг хэрэглэхээс татгалзан, бусад ялын төрөл хэлбэрийг сонгохыг урьтал болгож байна. 2018 оны байдлаар дэлхийн улс орнуудын хоригдлын тоон судалгааг авч үзвэл⁵:

Зураг.1.Дэлхийн улс орнуудын хоригдлын тоон судалгаа 2018 он



² Norrie, AA. *Critical Introduction to Criminal Law*. London. 1993p. 84-85

³ Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл ба шилжилтийн үе. Олон улсын симпозиумын баримт материал эмхэтгэл. УБ., 2006. 183 дахь тал

⁴ Д.Баярсайхан. Ялын бодлогыг шинэчлэх шаардлага, эрүүгийн эрх зүйн реформ. Эрх зүй. 2011. №1. 108-110 дэхь тал

⁵ Харьцуулсан эрүүгийн эрх зүй судлалын олон улсын хүрээлэнгийн судалгаа. 2017 он

Монгол Улс 100,000 хүнд ногдох хоригдлын тоогоор 262 үзүүлэлттэй, Ази тивд ял эдэлж буй хоригдлын тоогоор 27 дугаарт жагсаж байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны буюу гүйцэтгэлийн бодлого нь ялын зорилгыг хангахад чиглэгдсэн зохион байгуулалт, эрх зүй, нийгэм хамгааллын зэрэг цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх үзэл баримтлал бөгөөд хорих ял эдлүүлэх ажиллагаа нь дараах үндсэн шинж, зорилгыг агуулдаг. Үүнд:

1. Дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх;

2. Эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг хүндэтгэн сахидаг болон төлөвших;

3. Нийгмийн болон хүний хөгжлийг дэмжих, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх шаардлагыг агуулсан байхад чиглэгдэх ёстой байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ:

1. *Их Британи Умард Ирландын Нэгдсэн вант улс*

Тус улсын хорих ял эдлүүлэх байгууллага нь төвийн ба орон нутгийн шоронгийн байгууллагаас бүрдэнэ.

Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад гол төлөв хэрэг нь шүүхэд шилжихийн өмнөх болон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа хүмүүс хоригддог. Түүнчлэн:

а/ богино хугацаагаар хорих ял эдлэгсэд;

б/ торгууль төлөөгүй буюу бага хохиролтой гэмт хэрэг үйлдэгсэд;

в/ 21 хүртэлх насны хүүхэд залуучууд хоригддог байна.

Эдгээр төрлүүдэд ял эдлэгсдийн үйлдсэн гэмт хэргийн байдал, хүмүүжлийн түвшинг судлан тогтоож, улмаар тэднийг ял эдлүүлэх байгууллагын өөр төрөлд шилжүүлэх журам үйлчилдэг.

1969 оноос эхлэн тус улсын хорих ял эдлүүлэх төвлөрсөн байгууллага нь хугацааны хувьд 3 төрөлд буюу

а/ богино хугацааны буюу 18 сар хүртэл;

б/ дунд хугацааны буюу 1,5-5 жил хүртэл;

в/ урт хугацааны буюу 5 жилээс дээш хугацаатай гэж хуваасныг хорих ял эдлүүлэх ажиллагаанд ялгавартай хандах, зохих үр дүнд хүрэх ач холбогдолтойд тооцож байна.

Хэдийгээр ял эдлүүлэх төвлөрсөн байгууллагыг дээрх байдлаар ангилан хуваадаг ч үндсэндээ нээлттэй ба хаалттай гэж ангилдаг.

Нээлттэй байгууллагад зэвсэглэсэн хамгаалалт байхгүй, цонх нь төмөр торгүй бөгөөд тэнд хоригдон ял эдлэгсэд гадны байгууллагад очиж хөдөлмөрлөж болдог. Ийм хэлбэрийн байгууллага цөөн байгаа ч цаашид олшруулах чиглэл баримталж байгаа ажээ.

Хаалттай шорон нь зэвсэглэсэн харуул, өндөр, бөх бат хана зэргээр

нийгмээс хатуу тусгаарлагдсан байдаг онцлогтой.

Англи улсын шоронгийн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын талаар хэвлэлийн зарим нийтлэлээс тодруулан үзэж болно. Тухайлбал, нээлттэй дэглэмд ял эдэлж буй нэг ялтанд хоёр алба хаагч, хаалттай дэглэмийн нэг ялтанд 5 албан хаагч ноогддог бөгөөд хорих ангийн ажил хамгийн хүнд нөхцөлд тооцогддог тул тэнд ажиллагсдын цалин хангамж нийгмийн бусад хүмүүсийнхээс харьцангуй өндөр түвшинд тогтоогддог байна.

2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Энэ улсын эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад 1975 онд шинэчилэн найруулсан Эрүүгийн хууль, 1976 онд батлагдсан “Хорих ял эдлүүлэх болон хүмүүжил, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай хууль” тус тус хамаарна.

Хорих болон торгох ял оногдуулах, түүнчлэн хүмүүжил, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ зэрэг нь тус тусдаа өөрийн онцлогтой.

Герман улсын эрүүгийн ял оногдуулалтад торгох ял хамгийн өргөн хэрэглэгддэг. Торгох ял нь 5-360 өдөр байх ба торгуульд хамруулах цалингийн хэмжээг шүүх тогтоодог байна. Ингэхдээ өдөрт ногдох цэвэр орлогоос тооцдог бөгөөд торгуулийн нийт хэмжээ нь 2-10 мянган марк байжээ.

Хорих ял нь 1 сараас 15 жил, эсвэл бүх насаар нь хорих хугацаатай. Бүх насаар нь хорих гэдэг нь харьцангуй ойлголт юм. Хоригдол 15-аас доошгүй жил ял эдэлсний дараа түүний үлдсэн ялыг зохих нөхцөлтэйгээр хойшлуулж болдог байна.

Герман улсад хорих ял эдлүүлэх ажиллагааг дэглэмийн төрлийн хувьд нээлттэй ба хаалттай гэсэн хоёр хэлбэрээр эдлүүлдэг байна.

Нээлттэй хорих байгууллагад 6 сар хүртэл богино хугацаагаар хорих ял шийтгүүлэгчид, эсвэл үйлдсэн гэмт хэргийн хор аюул нь бага хоригдлын ялыг эдлүүлнэ. Харин нээлттэй хорих байгууллагын тоо нь харьцангуй цөөн байдаг.

Хаалттай хорих байгууллага нь Герман улсын ял эдлүүлэх байгууллагын үндсэн төрөл бөгөөд тооны хувьд ч олон байдаг ажээ.

Насанд хүрсэн бүх хоригдол зургаан сараас дээш хугацааны хорих ял шийтгүүлсэн бол эхлээд ганцаарчилсан тасалгаанд байж шоронгийн амьдралтай танилцдаг байна. Энэ хугацаанд ял эдлэгсдийн дэглэм, хөдөлмөр зохион байгуулалт, сургалт, хүмүүжлийн ажлыг цаашид хэрхэн зохион байгуулахтай холбогдсон судалгаа хийгдэнэ.

Харин хаалттай дэглэмд ял эдлүүлэхдээ нээлттэй дэглэмийн хоригдлуудтай харьцуулбал эрх нь илүү хязгаарлагдмал шинжтэй боловч ялтны ахуй хангалт, орон байр, хувцас, хоол хүнсний хангалт ижил байдаг ажээ.

Хаалттай хорих анги нь өндөржүүлсэн хамгаалалттай, ялтны өрөө нь бие засах газар, угаалтуур, ахуйн хэрэглээний зүйл тавих тавиур, бичгийн ширээ, сандал, номын тавиур, радио телевизээр тоноглогдсон байдаг. Тэд зураг зурах, мужаан, тавилгын үйлдвэрлэл, гутал болон оёдлын бүтээгдэхүүн, хүүхдийн

тоглоом, угаалга-хими цэвэрлэгээ, авто машины зарим төрлийн сэлбэг хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл засвар зэрэг ажлыг хийдэг. Энэ дэглэмд хоригдлын ялыг эдлүүлэхдээ доод, дунд, дээд гэсэн 3 нөхцөл байх бөгөөд нөхцөлөөсөө шалтгаалж хоригдлын эрх, ахуй хангалт, дэглэм зэрэг нь тодорхойлогддог. Хоригдлууд нэг өнгийн, харин онц аюултай гэмт хэрэгтнүүд нь эрээн хувцас өмсдөг байна.

Вуфпертал дахь хаалттай хорих анги 1980 онд нээгдсэн бөгөөд нийт 495 хүний /хоригдол/ багтаамжтай ганцаарчлан хорих 394 хүний өрөөтэй байна. Хамгаалалтын хашаа нь 4 м өндөр, 840 метрийн урттай, хашаанд суурилсан гадна дотор талыг харах боломжтой, телекамер, холбоо дохиоллын хэрэгслээр тоноглогдсон 4 ширхэг харуулын посттой, хашааны дотор 47250 метр квадрат талбайтай байна. Хорих ангийн дэргэд дотоод холбоо дохиоллоор тоноглогдсон 40 албан хаагчийн орон сууцтай байна. Энэхүү хорих ангийг барихад тухайн үеийн тооцоогоор 100 сая DM /дойчмарк/ зарцуулсан ба нэг хоригдолд өдөрт 150 DM зарцуулдаг байна. Тус хорих ангийн албан хаагчийн орон тоог авч үзвэл хуульч 2, лам 3, сэтгэл зүйч 4, эмч 1, багш 3, нийгмийн ажилтан 7, захиргааны дээд албан тушаалын орон тоо 8, захиргааны дунд албан тушаалын орон тоо 22, харуул хамгаалалтын ажилтны орон тоо 180, аж ахуйн ажилтан 14, нийт 244 алба хаагчидтай байна.

Эргэлт уулзалтын хувьд хязгааргүй бөгөөд дараах хуваариар уулзуулдаг байна. Даваа гаригт 9.00-15.30, Лхагва, Баасан гаригт 9,00-15.00, Пүрэв гаригт 12.00-18.30 цагт эргэлт уулзалт хийх ба үүнийг бие даасан эргэлт уулзалтын чиг үүрэг бүхий алба зохион байгуулдаг.

Хоригдолд Христийн мэндэлсний баяр, улаан өндөгний баяр, төрсөн өдөр зэрэгт нэг удаа 5 кг-аас дээшгүй жинтэй илгээмж авах ба түүнд хүнсний бүтээгдэхүүн, амттан байж болно. Эдгээрээс гадна хоригдол өөрөө чухал гэсэн баярын өдөр 1 удаа илгээмж авах эрхтэй байна. Илгээмжид хорих ангийн аюулгүй байдалд нөлөөлөх болон хориглосон эд зүйл, бүтээгдэхүүнийг оруулахгүй. Тухайлбал: архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис, эм тариа гэх мэт.

Өнгөрсөн зууны эцэс хүртэл Герман улсын эрүүгийн ял эдлүүлэх үйл ажиллагаа, эрх зүйн системд “Хүмүүжил, аюулгүй байдлын арга хэмжээ” гэсэн төрөл байсаар ирсэн байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 61-р зүйлд зааснаар хүмүүжил аюулгүй байдлын арга хэмжээнд, сэтгэл мэдрэлийн болон хар тамхи хэрэглэгчид, архаг архичдын эмнэлэгт хэвтүүлэх, хараа хяналтад байлгах, машин жолоодох эрхийг хасах, ямар нэг тодорхой мэргэжлээр ажиллахыг хориглох, гэмт хэрэг санаатай үйлдэж хоёроос доошгүй жилийн ял шийтгэгдсэн хоригдол, дахин давтан шийтгэгдэж хорих ял эдлэгсдийг 10 хүртэл жил хорих зэрэг арга хэмжээнүүд багтана.

Чухам ямар нөхцөлд дээрх арга хэмжээнд хамааруулж болохыг Эрүүгийн хуульдаа тодорхой заасан байна⁶.

⁶ О.Пүрэвсүрэн.Герман Улсын Хорих ял эдлүүлэх ажиллагаа.УБ.,2014 он,45 дахь тал.

3. Бүгд Найрамдах Франц улс

Франц Улс бол эх газрын эрх зүйн системтэй орон бөгөөд нэг онцлог бол Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Ял эдлүүлэх хууль тогтоомжийн хэм хэмжээний түүхэн эх сурвалж нь шүүхийн бус, бие даасан тусгай хууль эрхийн акт байсаар ирсэнд оршино.

Францын эрх зүйн гол бааз нь шинэ Эрүүгийн хууль, 1958 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Пенитенциарын хууль зэргээс бүрдэнэ.

Францын шинэчлэгдсэн эрүүгийн хуульд зааснаар а/ эрүүгийн гэмт хэрэг, б/ эрүүгийн гэмт явдал, в/ эрүүгийн зөрчил гэж гурав ангилдаг байна.

Эрүүгийн хэргийн зохих зүйлчлэлээр шийтгэгдэгсдэд бүх насаар нь хорих буюу бүх насаар нь эчнээ ял оногдуулах, 15-30 жил хорих, тийм хэмжээгээр эчнээ ял оногдуулдаг,

Эрүүгийн гэмт явдалд холбогдон шийтгэгдэгсдэд хүмүүжлийн ял буюу 6 сараас 10 жил шоронд хорих, торгох, хүүтэй торгууль төлөх, нийгмийн тусын тулд үнэ хөлсгүй ажиллуулах, эрхийг нь хасах хязгаарлах ял оногдуулдаг байна. Хүүтэй торгууль ногдуулах ял нь нэлээд онцлогтой. Хэрэгтэн этгээдэд шүүх 2000-аас дээшгүй франкийн торгууль оногдуулж, уг мөнгийг төлөх өдрийн тоо, өдөр тутамд төлөх хүүгийн хэмжээг тогтоож өгдөг. Торгуулийн мөнгийг төлөх хугацааг 360 хоногоос хэтрүүлэхгүйгээр шүүх тогтоодог байна. Нийгмийн ашиг тусын төлөө үнэ хөлсгүй ажиллуулах хугацаа нь 18 сараас хэтрэхгүйгээр тогтоогддог.

Эрүүгийн зөрчил үйлдэгсдэд торгох, эрхийг нь хасах, хязгаарлах ял оногдуулдаг байна. Шүүх түр хугацаагаар тухайн хэрэгтний улс төрийн, иргэний, гэр бүлийн эрхийг хасах шийдвэр гаргадаг. Тухайлбал: сонгох, сонгогдох, шүүхэд гэрчлэх, шинжээчээр оролцох, асран хамгаалах, хамгаалуулах эрхийг хасдаг байна, Сонгох, сонгогдох эрх нь хасагдсан хүн мөн тэр хугацаанд төрийн байгууллагад ажиллах эрхгүй болдог онцлогтой.

Франц улсын ял эдлүүлэх байгууллагын бүтэц нь 1/ Мөрдөн тусгаарлах газар, 2/ Ял эдлүүлэх байгууллага гэсэн 2 төрөл хуваагдах ба ял эдлүүлэх байгууллага нь насанд хүрэгчдийн төвлөрсөн болон орон нутгийн хорих байгууллага, насанд хүрээгүйчүүдийн сургалт, хүмүүжлийн байгууллагаас бүрдэнэ.

а) Төвлөрсөн хорих байгууллагад нэг жилээс дээш хугацаагаар ял эдлэгсдийн ялыг эдлүүлдэг. Шинээр ирсэн бүх хоригдлыг шоронгийн байдалд дасгахын тулд 45 хүртэлх хоног ганцаарчилсан тасалгаанд байлгадаг ба тэднийг засарч хүмүүжих төлөвөө олсон, олоогүй, эргэлзээтэй байгаа гэж ангилдаг. Засрах төлөвөө олсон хоригдлууд өдөр нь хамтарч ажиллаад, шөнө нь ганцаарчилсан тасалгаанд байрладаг байна. Засрал хүмүүжлийн түвшингээрээ “сайн” гэж үнэлэгдсэн хоригдлын ахуй нөхцөлийг сайжруулах, хагас хөнгөн дэглэмд шилжүүлэн шоронгоос гадна ажиллах, төрөл төрөгсөдтэйгөө уулзах, хугацаанаас нь өмнө тэнсэн суллах гэх мэт урамшуулал үзүүлдэг байна.

б) Орон нутгийн засаг захиргаа өөрийн мэдэлд хорих байгууллагыг байгуулдаг бөгөөд тэр нь баривчлагдагсдын байр, хүмүүжлийн төв гэсэн ангилалтай байдаг. Орон нутгийн хорих байгууллагад шүүхийн шийдвэр хүчин

төгөлдөр болохыг хүлээж байгаа яллагдагч, хор холбогдол бага эрүүгийн гэмт хэрэг үйлдэгчид, нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлэгчдийг хорьдог байна.

в) Насанд хүрээгүй хоригдлыг сургалт хүмүүжлийн байгууллага болон сургуульд байлгаж ялыг нь эдлүүлдэг.⁷

Францын ял эдлүүлэх ажиллагааны нэг онцлог бол насанд хүрээгүй хоригдлыг шашин, буяны болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагад ялаа эдлэхийг зөвшөөрдөг явдал бөгөөд шүүх хоригдлын эдлэх ялын хугацааг хасаж багасгах, тэднийг хугацаанаас нь өмнө тэнсэн суллахад их өргөн эрх эдэлдэг байдал юм.

Францын Эрүүгийн хуулийн 125-132 дугаар зүйлүүдэд хагас эрх чөлөөтэй байдлаар ял эдлүүлэх нөхцөлийг тодорхойлон заажээ, Энэ нөхцөлд харгалзан үзэх гол хүчин зүйлүүд нь:

- а/ Мэргэжлийн онцлог, шаардлага;
- б/ Мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтад хамрагддаг;
- в/ Гэр бүлийн амьдралдаа шийдвэрлэх нөлөө бүхий үүрэг гүйцэтгэдэг;
- д/ Курс эмчилгээ хийлгэж байгаа хүмүүс хамрагдана.

Хагас эрх чөлөөтэй байдлаар шийтгэгдэн гадуур байгаа хоригдлууд ял эдлүүлэх байгууллагадаа эргэн ирж бүртгүүлж байх үүрэг хүлээдэг байна.

Засрахад эргэлзээтэй, засрахгүй хоригдлын хувьд хязгаарлагдмал эрхийг эдлэх бөгөөд асуудлыг тусгай шүүгч хариуцаж хугацаанаас нь өмнө суллах, мөн ялын хугацааг богиносгох хүртэл эрхийг эдэлдэг. Уг дэглэмийн хоригдол хүмүүжилтэй, ял эдлэх явцдаа ямар нэг зөрчил гаргаагүй бол засрах найдлагатай буюу дээд, илүү нээлттэй дэглэмд шилжүүлж болдог онцлогтой байна.

Хагас эрх чөлөөтэй болон хязгаарлагдмал дэглэмүүдэд ял эдлэх хоригдлоор хэдэн арван сорилыг бөглүүлж, түүний зан байдал, ямар шалтгаанаар гэмт хэрэг үйлдэх болсон, ар гэр, ахуй амьдрал гээд олон асуудлыг тодорхойлдог. Үүнд мэргэжлийн сэтгэл судлаачид, багш, сурган хүмүүжүүлэгч нар оролцдог тул ямар ч алдаа гаргахгүй байх нөхцөл бүрддэг байна.

4. Бүгд Найрамдах Польш Улс

Тус улсын хорих байгууллага 1917 оны тусгаар тогтнолын тэмцлийн дараа буюу 1919 онд үүсгэн байгуулагдсан байна. Хорих байгууллага нь 1920 оноос хоригдлыг хөдөлмөр эрхлүүлж эхэлсэн бөгөөд социалист тогтолцоотой байсан улс орнуудын хамгийн түрүүнд хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнд хүрч ажилласан талаар дурдсан юм.

Польш улс нь 38,5 сая хүн амтай бөгөөд засаг захиргааны 15 мужид хуваагддаг ба муж бүрд Хорих ял эдлүүлэх газартай 87 хорих анги, 70 цагдан хорих байр, нийт 157 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, системийн хэмжээнд 83152 сэжигтэн, хоригдол хоригддог.

⁷ Н.Гантулга.Хүний эрх ба хорих байгууллага.УБ.,2015 он. 59 дэх тал.

Польш улсад хорих ял эдлүүлэх ажиллагааг хууль, хуульчилсан актуудын хүрээнд хэрэгжүүлдэг. Шоронгууд нь хаалттай, хагас хаалттай, нээлттэй гэсэн 3 дэглэмтэй байдаг ба гэмт хэрэг үйлдсэн байдал зэргээс нь шалтгаалаад эдгээр дэглэмүүдэд ял эдлэгсдийг хуваарилдаг байна.

Нээлттэй дэглэмийн хоригдлууд тусгай хамгаалалттайгаар тухайн шоронгийнхоо ахуйн үйлчилгээний болон гадуур аж ахуйн нэгж байгууллагад гэрээгээр ажилладаг ба хагас хаалттай дэглэмийн хорих ангийн хоригдлууд тухайн хорих ангийнхаа барилгын материал, машины эд анги, засвар, гэр ахуйн барааны сэлбэг зэрэг үйлдвэрт ажилладаг.

Хаалттай хорих ангиудад ихэвчлэн онц аюултай гэмт хэрэгтнүүд ял эдэлдэг тул тэд ажил хийдэггүй.

Нийт хорих ангиудад “Кофеда” гэж нэрлэгддэг Польш Улсын Засгийн газрын бус олон нийтийн байгууллага /нийгэмлэг/ үйл ажиллагаа явуулдаг бөгөөд уг нийгэмлэгийн үйл ажиллагааны чиглэл нь:

а/ шорон дахь хүчирхийллийг багасгахад чиглэсэн сургалтыг зохион байгуулж, тодорхой зөвлөмж бэлтгэн хорих ангиудад тараах;

б/ хоригдлыг суллахын өмнө эрх чөлөөт нийгмийн амьдралд дасгах зорилгоор хуулийн зөвлөмж өгөх;

в/ суллагдсан хүмүүс нийгмийн эмзэг давхаргад хамрагдах бол тэдэнд компьютер, мэдээллийн болон оёдлын сургалтыг үнэ төлбөргүй явуулах;

г/ суллагдаад орон гэргүй хүмүүст 7 хоног байрлах үнэ төлбөргүй байраар хангах ажиллагааг үзүүлдэг.

Дэглэмээс хамааран эргэлт, уулзалтын тоо харилцан адилгүй байдаг.

Урьдчилан хорих байр нь хорих байгууллагын харьяанд үйл ажиллагааг явуулдаг байна. Нэг хоригдлын байрны эзэмшилд оногдох талбай 3 м² байдаг. Нийт хорих ангиуд ихэвчлэн телекамерын системтэй 4,5-5 метр өндөр бетонон хашаа, дотор хаалганууд нь зузаан төмрөөр хийгдсэн байдаг.

Ажиллагсдын олонх нь сурган, сэтгэл судлалын мэргэжилтнүүд ажилладаг бөгөөд 1 хүнд дунджаар 50 хоригдол ногддог тул ял эдлэгсдийн сэтгэл зүйд сайн нөлөөлөл үзүүлэхэд онцгой анхаарч байгаа нь харагдаж байна.

Хоригдлуудад өдөрт 3 удаа 3800 ккалын илчлэг бүхий хоол олгодог байдлыг дэлхийн жишигтэй харьцуулахад нэлээд өндөр тоо юм. Хорих ангид тогтоосон дэглэм зөрчигчдөд сахилгын байранд 28 хүртэл хоног хорих шийтгэл оногдуулдаг байна.

Хорих байгууллагын “Албан хаагчдын хөгжлийн төв” нь сургалтын танхим, техник хэрэгслээр бүрэн хангагдан, сургалтын үйл ажиллагааг янз бүрийн хугацаагаар тогтмол явуулахын зэрэгцээ албан хаагчдын ая тухтай амрах орчныг сайтар бүрдүүлсэн байна. Полов, Калиш, Кулач зэрэг газарт албан хаагчдын нэгдсэн хөгжлийн төвүүд, мужийн хэмжээнд 11 сургалтын төвд албан хаагчдыг сургах мэргэшүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Тус улсын хорих байгууллага нь 29467 албан хаагчтайгаас 26942 нь цэргийн, 2525 нь энгийнээр ажилладаг.

Хорих байгууллагын удирдах газар нь харуул хамгаалалт, нийгмийн ажил, мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсүүдийг хариуцсан нэг, төсөв, санхүү, бүтээн байгуулалтын хэлтсийг хариуцсан нэг, нийт 2 дэд даргатай, бусад хэлтсүүд нь шууд удирдах газрын даргын удирдлагад ажиллахаар тогтоосон бүтэцтэй ба харин хорих анги нь нийгмийн ажлын, хамгаалалтын, аж ахуй бүтээн байгуулалтын, санхүүгийн, архивын, эмнэлгийн гэсэн албадын бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Хорих ангиудын нэг онцлог нь цагдан хоригдогч болон нээлттэй, хагас нээлттэй, хаалттай дэглэмийн хоригдлуудыг байршлын хувьд тусгаарлалттайгаар нэг хорих ангид хорьдог ба Пиотрков, Трибуналски дахь шинэ хорих анги нь мөн тийм зохион байгуулалттай 700 хүний багтаамжтай, 400 хорих өрөөтэй, техник, технологийн орчин үеийн дэвшлийг ашиглан байгуулсан, өндөр стандарт бүхий хорих ангитай. Уг хорих ангийн үйл ажиллагаа, нөхцөлийн онцлог талуудаас дурдвал:

- Хамгаалалтын 5,5 метр өндөртэй бетонон хашаа, 3 давхар торон хамгаалалт бүхий дотоод бүс дэх хашаа, хамгаалалтын бүсэд дугараг хэлбэртэй, цаг агаарын ямар ч нөхцөлд бүх талаа хянах боломжтой, 8 метрийн өндөр харуулын цамхагтай.

- Хамгаалалтын хашааны хаалга бусад хонгил, жигүүрүүдийн хаалга цахилгаан соронзон цоожтой, электрон түлхүүр нь тус тусдаа бүсийн хамгаалалтын ахлагчид хадгалагддаг, 2 жигүүрийн буюу хонгилын хаалга нэгэн зэрэг онгойхгүй байхаар хийгдсэн.

- Хорих өрөөний хаалга, цонхны гадна, дотор давхар хамгаалалттай, хорих өрөө хооронд харьцах боломжийг хаасан.

- Хяналтын төвийн тусгайлсан байранд 2 албан хаагч ажилладаг, хавтгай дэлгэц бүхий хяналтын дурангийн систем, бүх төрлийн утсан холбоо, хорих өрөөний цэвэр ус, цахилгаан хамгаалалтын цоожны төвлөрсөн удирдлагыг нэг дор байрлуулсан.

- Хорих байр руу нэвтрэх хэсэгт металл илрүүлэгч хаалганаас гадна хүний биеийг нэвт харах рентген төхөөрөмж суурилуулсан.

- Байнгын ажиллагаатай тусгай бүлэгтэй.

- Нийтийн гал тогоо, угаалгын байрыг тусад нь байрлуулж, үндсэн хорих байртай хонгилоор холбосон.

- Албан хаагчдын бэлтгэл сургалтад зориулсан спорт заал, бялдаржуулах танхим, урт болон богино бууны буудлагын механикжсан байртай.

- Алба хаагчид нь хамгаалалтын бамбай, тусгай хэрэгсэл, гаваар хангагдсан.

- Амиа хорлохыг завдсан, албан хаагчдад халдсан, хүч хэрэглэсэн эсэргүүцэл үзүүлсэн хоригдогчийг тусгаарлах өрөөтэй зэрэг байдлаар орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан, аюулгүй байдлыг бүрэн хангасан хорих анги юм.

Краков хот дахь хорих ял эдлүүлэх газрын дэргэдэх хоригдсон этгээдэд

эмнэлгийн тусламж үзүүлэх болон мэс заслын тасагтай байна. Энэ нь эмнэлэгийг шаардлага бүхий тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, мэргэжлийн зохих ур чадвар бүхий ажилтнуудтай, зүрх, элэг болон эрхтэн шилжүүлэх зэрэг хүнд хагалгаанаас бусад бүх мэс ажилбарыг өөрсдөө хийдэг, түүнчлэн хамгийн түгээмэл хийгддэг хагалгаа нь амиа хорлох эсвэл эмнэлэгт хэвтэх зорилгоор бие эрхтэндээ гэмтэл учруулсан, элдэв төмөр болон бусад зүйл залгисан тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авдаг байна.

Варшав хотын Грочив дүүрэг дэх эмэгтэй хоригдогч, хоригдлыг хорих, орчин нөхцөл, эргэлт уулзалтын хувьд цагдан хоригдож буй бол тусгайлсан өрөөнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол тусгай хаалганы цаанаас, нээлттэй дэглэмтэй бол ил зааланд уулздаг байхаар зохион байгуулсны зэрэгцээ хоригдогсдын ар гар эргэлтээр ирэх үед хүүхдийн тоглох талбай гарган тохижуулсан байна. Варшав хотын Мокотив дэх хорих ангид онц аюултай гэмт хэрэгтнийг хорих өрөөний болон салхилах талбайн хамгаалалт нь өндөр түвшинд хийгдсэн, хамгаалалтын орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан онцлогтой байна.

Европын Холбооны Улсууд дахь хорих ял эдлүүлэх дэглэмийн онцлог нь хорих ял шийтгүүлсэн этгээдийг ихэвчлэн нээлттэй, хаалттай дэглэмд эдлүүлэх ба зарим улсад хагас хаалттай, завсрын, дунд шатны гэх мэтээр нэрлэгдсэн нээлттэйгээс хаалттай руу эсвэл эсрэгээр шилжүүлэхэд ашигладаг дундын дэглэм бүхий хорих анги байгууллага ажилладаг.

Харин ХБНГУ улсад хаалттай, нээлттэй дэглэм нь дотроо хэд хэдэн зэрэглэлд хуваагддаг онцлогтой. Хаалттай хорих ангиуд нь харуул хамгаалалт хяналтын төхөөрөмжөөр маш сайн тоноглогдсон барилга байгууламж, төрөл бүрийн зэвсэг хэрэгслээр хангагдсан албан хаагчид үүрэг гүйцэтгэдэг ба тэдний тоо ихэвчлэн 2 хоригдолд 1 албан хаагч байхаар тооцсон байдаг бол зарим тохиолдолд тэнцүү буюу албан хаагчдын тоо илүү байдаг онцлогтой. Хорих ангийн дэргэд албан хаагчдын орон сууц зайлшгүй байх ба түүнд албан хаагчид амьдарна. Нээлттэй дэглэмийн хувьд хоригдлыг чөлөөт нийгэмд бие даан амьдрахад чиглэгдсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлдэг гэж хэлж болно, Тэдний эргэлт уулзалт чөлөөтэй бөгөөд хорих ангийн харуул хамгаалалт, нөхцөл нь тэднийг бие дааж амьдрах орчинг бүрдүүлж өгсөн байдаг. Тухайлбал, өөрсдөө хоолоо хийж идэх, гадны аж ахуйн нэгжид хөдөлмөрлөх, ийнхүү явахдаа харуул хамгаалалтгүй байх бөгөөд гэрээний үндсэн дээр зөвхөн итгэлцэл дээр тулгуурлан хэрэгжүүлдэг онцлогтой. Европын холбооны улсуудын хоригдлыг нийгэмшүүлэхэд ашигладаг нийтлэг арга бол Христын шашны сургаал “Библи”-ийг судлуулж “ертөнцийн эзэн” түүнд итгэн дагавал гэм нүглийг өршөөх тухай шашны үзэл суртлыг өргөнөөр ашиглах ба хорих анги бүрд дээрх шашны байнгын ажиллагаатай сүм хийд болон лам буюу номлогч ажилладаг онцлогтой⁸.

5. Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын шүүхээс оногдуулдаг ялын төрөл нь ихэвчлэн барьцаалах, торгууль ногдуулах, хорих ял юм. Барьцаалах гэдэг нь ялыг тэнсэж, шүүхийн шийдвэр

⁸ М.Алтан-Очир.”Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалтын асуудал” хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. УБ.,2019 он. 71 дэх тал

биелүүлэхийг тодорхой хугацаагаар хойшлуулах ойлголт бөгөөд хорихоос бусад төрлийн ялд багтана. Барьцаалах ялыг хэрхэн оногдуулахыг АНУ-ын хууль тогтоомжид нарийвчлан тусгасны дээр дундаж хугацаа нь 1.5 жил байхаар заажээ. Барьцаалах ялын үндсэн нөхцөл нь энэ төрлийн ял эдлэх хугацаандаа шинээр гэмт хэрэг үйлдэхгүй байх явдал юм. Хэрэв барьцаалах, торгох ялыг нэгэн зэрэг оногдуулсан бол торгуулийн төлбөрөө төлж барагдуулах явдал ял эдлэлтийн биелэлтийг харуулах нэг чухал нөхцөл болдог байна. Хэрэв ялтан барьцаалах ялын нөхцөлийг зөрчвөл ял эдлүүлэх байгууллагын санаачилгаар шүүх:

1 Барьцаалах хугацаа, нөхцөлийг өөрчлөх

2. Барьцаалах ялыг өөрчлөн үйлдсэн хэрэг, зөрчилд нь тохирсон өөр төрлийн ялаар солих шийдвэр гаргадаг байна.

АНУ-д хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг ялын төрөл бол торгууль юм.

Үйлдсэн гэмт хэргийн байдлаас шалтгаалан 1000 - 500000 хүртэл долларын торгох ял оногдуулдаг байна. Торгуулийн мөнгийг нэн яаралтай төлөх, эсвэл зохих хуваарьтайгаар төлөхийг шүүх гаргасан шийдвэртээ заадаг. Торгуулийн мөнгө 30-90 хоногийн дотор төлөгдөөгүй бол энэ ял биелэгдээгүйд тооцдог байна.

Орчин цагийн АНУ-ын ял эдлүүлэх байгууллагын бүтцэд Пенсилваний ялангуяа “Оборн” систем голлох байр эзэлдэг. АНУ-ын шоронгуудад хатуу тогтоогдсон дэглэм журам, дэвшилтэт хэлбэрийн аль аль нь үйлчилдэг. Холбооны болон мужийн хорих ял эдлүүлэх байгууллагын бүтэц нь нээлттэй, хаалттай гэсэн үндсэн хоёр хэсэг тэдгээрийн дунд завсрын, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнийг хорьж ялыг нь эдлүүлэх онцгой шоронгоос бүрдэнэ.

Хорих байгууллагыг дараах байдлаар ангилж хорих ялыг эдлүүлдэг:

1. Засаг захиргааны харьяалал:

а/ холбооны, б/ мужийн, в/ орон нутгийн;

2. Хууль сахиулах чиг үүрэг:

а/ цагдаагийн, б/ шүүхийн, в/ шоронгийн;

2. Байршил:

а/ институцийн, б/ институцийн бус;

4. Нас:

а/ насанд хүрэгчдийн, б/ насанд хүрээгүйчүүдийн;

5. Бусад хүчин зүйлсээр нь:

а/ үйл ажиллагааны цар хүрээ, б/ хүйс, в/ гэмт үйлдлийн төрөл, г/ тусгай хөтөлбөр (сургалтын) гэж ангилдаг байна.

Орон нутгийн шорон ба бусад хорих анги нь хоорондоо зарчмын ялгаатай бөгөөд энэ нь орон нутгийн шорон урьдчилан хорих чиг үүргийг гүйцэтгэдэг. Бусад хорих анги нь мужийн болон холбооны засаг захиргаанд харьяалагддаг бол орон нутгийн шорон орон нутгийн засаг захиргаанд харьяалагддаг байна. Орон нутгийн шоронд гол төлөв цөөн жилийн хорих ялтай хоригдлууд байрладаг. Орон нутгийн

хорих байгууллагуудад таван жилд нэг удаа тооллого хийдэг. Жил бүр түүврийн аргаар статистик мэдээлэл цуглуулдаг байна. Энэхүү статистик мэдээлэл нь орон нутгийн хорих байгууллагуудын өөрчлөлтийн төлөв, чиг хандлагыг тодорхойлох боломж олгодог байна. Орон нутгийн шоронгуудад аюул багатайд тооцогдох хоригдлуудыг хорьж ялыг нь эдлүүлдэг байна.

Насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг тэдэнд зориулж тусгайлан байгуулсан хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг. Тэндхийн дэглэм, харуул хамгаалалтын нөхцөл насанд хүрэгчидтэй жишихэд харьцангуй зөөлөн байдаг. Насанд хүрээгүй хоригдлууд өдөрт нь шоронгийн байрлалд ажиллаж, сурах бөгөөд шөнө нь гэртээ очиж хонож болдог. Энэ байдал хоригдлуудын хүмүүжилд нааштай нөлөө үзүүлдэг болох нь практикаар нотлогджээ.

Калифорни мужийн хорих байгууллагын онцлог:

Хорих байгууллагын нэн тэргүүнд хийх ажил бол шинээр ирж буй хоригдлыг байраар хангах ба үүний тулд хоригдлыг ангилж ялгах үйл явцыг хэрэгжүүлдэг. Энд зөвхөн тухайн хоригдлын байрны асуудлаас гадна ажил эрхлэлт, эрүүл ахуйн нөхцөл зэрэг зүйлс хамаарна. Тухайн хоригдлын талаарх эрсдэлийн үнэлгээ нь түүний цаашдын ял эдлүүлэх хугацааг тодорхойлдог. Жишээ нь. хоригдол гэр бүлийн хүмүүстэйгээ олон удаагийн давтамжтайгаар уулзах боломжтой байх, зарим хоригдол уулзах боломжоор бүрмөсөн хязгаарлагдсан тохиолдол байдаг. 2 сарын турш тухайн хоригдлын эрсдэлийн үнэлгээ гарч, түүний дагуу мужийн 33 хорих байгууллагууд эсвэл сургалтын төвийн аль нэгэнд хуваарилдаг.

Хоригдлыг ангилах үйл явц нь дараах үе шатуудаас бүрддэг. Энэ нь: эрүүл мэндийн үзлэг, сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг, боловсролын түвшин тогтоох тест г.м. Эдгээрийн үр дүнд хоригдол бүр хувийн оноо авах бөгөөд тэдгээрийн нийлбэрээр түүний ямар дэглэм, зэрэглэлд хуваарилах, сургалтад хамрагдах эсэхийг тодорхойлдог. Энэхүү үйл явц жил бүхэн явагдах онцлогтой бөгөөд 2003 оноос үнэлгээний аргыг анх туршиж эхэлжээ. Үнэлгээний нийлбэр оноо нь бага байвал тухайн хоригдол сургалтад хамрагдах хэрэгцээ багатай, эсрэгээр нийлбэр оноо нь их байвал олон тооны сургалтад хамрагдах шаардлагатай ангилалд багтдаг. Хорих байгууллага нь хоригдлыг юуны түрүүнд хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, түүний ялын түүхийг судлан доорх 3 шалгуурыг үндэслэн ангилдаг. Энэ нь үйлдсэн гэмт хэргийн хор уршгаас хамаарч, давтан гэмт хэрэг үйлдсэн эсэх, хоригдлын хэрэгцээнд тохирох сургалтын цогц хөтөлбөрөөр нь ангилдаг.

Калифорни мужийн хорих ангиуд нь үндсэн 4 төрлийн дэглэмтэй. Үүнд: I, II, III, IV гэсэн зэрэглэлд хуваагддаг. Хорих ангийн дэглэм нь дараах төрөлтэй:

- Нээлттэй хорих;
- Завсрын хорих;
- Хаалттай хорих;
- Онцгой /хаалттай/ хорих.

Зарим хорих ангид дээрх бүх дэглэмийн хоригдлууд байрладаг бол зарим тохиолдолд тухайн хоригдолд тохирох зэрэглэл бүхий хорих анги олдохгүй байх нь элбэг тохиолдох тул энэ асуудлыг хорих ангийн удирдлага эцэслэн шийдвэрлэдэг.

Хаалттай хорихын /онцгой/ хоригдлууд өдрийн ихэнх цагийг хатуу хяналтад өнгөрөөдөг бол нээлттэй хорихын хоригдлууд өдрийн турш гадуур ажиллаж, ямар нэг хяналт, хязгаарлалтыг мэдэрдэггүй байна.


Хоригдлын байрны хомсдол нь хаалттай дэглэмтэй хорихын хоригдлуудыг завсрын дэглэмтэй хориход байрлахад хүргэсэн байна. Нэг хорих ангид өөр өөр дэглэмтэй хоригдлууд байрлах үйл явц улам дэлгэрсэн байна. Эдгээр хорих байгууллагуудыг “олон дэглэмт” хорих байгууламж гэж нэрлэх болжээ. 19-20 зууны үеийн АНУ-д шоронгийн тогтолцоо нь илүү дэвшилттэй хэлбэр агуулгатай байсан байна.

Нээлттэй хорих анги нь зэвсэглэсэн хамгаалалтгүй, хөнгөн дэглэмтэй, тэнд хоригдогсад гадны байгууллагад хүртэл хөдөлмөр эрхлэх боломжтой байна. Нээлттэй дэглэмд хорих ял эдлэгсдийн эрхэлдэг хөдөлмөрийн гол чиглэл нь барилга байгууламж барих, зам засах, хөдөө аж ахуйн болон бусад ажил байдаг. Энэ зэрэглэлийн шоронгууд нь хашаагаар хүрээлэгдсэн, зэвсэглэсэн харуулын постгүй, дохиолол, камерын тусламжтайгаар хашаан доторх орчноо хянаж байдаг. Улсын хэмжээнд гурван шоронгийн нэг нь энэ зэрэглэлд хамаардаг боловч нийт хоригдлуудын 12% нь л ийм төрлийн шоронд хоригддог гэсэн тооцоо гарчээ.

Хаалттай хорих ангид хамаарах шоронгууд зэвсэглэсэн хамгаалалттай дээгүүрээ өргөст торон хамгаалалт бүхий хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн байдаг. Байшин барилгын хувьд янз бүр, 150 шахам ганцаарчлан хорих өрөөнүүд бүхий барилгууд байдаг. 1984 оны байдлаар улсын хэмжээнд нийт шоронгуудын 40% нь энэ зэрэглэлд хамаардаг ба нийт хоригдлуудын 44% нь энэ төрлийн шоронгуудад ял эдэлдэг байжээ.

Хаалттай хорих анги /онцгой/ нь онц аюултай гэмт хэрэгтнүүдийг хорьдог өндөр хана бүхий хамгаалалттай байдаг ажээ. Тэнд хоригдогсдыг гадагш гарч ажиллахыг хориглоно. Энэ нь дээд зэргийн харуул хамгаалалттай шорон. Энэ зэрэглэлийн шоронгууд нь гадуураа 18-25 фут /6-8 метр/ өндөртэй хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн, ажиглалтын цамхгууд дээр зэвсэглэсэн харуултай байдаг⁹.

Дэлхийн ихэнх орны ял эдлүүлэх ажиллагааны буюу гүйцэтгэлийн менежмент нь ялын зорилгыг хангахад чиглэгдсэн удирдлага, зохион байгуулалт, эрх зүй, нийгэм хамгааллын зэрэг цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх үзэл баримтлал бөгөөд дэлхий нийтэд дараах үндсэн 2 чиглэл байгааг харж болно.



Энэхүү загвар, хандлага нь ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг нийгэм, олон нийтэд тулгуурласан олон талт хэлбэрээр хэрэгжүүлэхэд анхаарч байгаагийн

⁹ М.Алтан-Очир."Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалтын асуудал" хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2019 он. 76 дахь тал

илрэл бөгөөд ял шийтгүүлсэн хүнийг хууль сахин биелүүлэгч - иргэн (a law-abiding citizen) болгон төлөвшүүлж, нийгмийн амьдралд эргэн оруулах асуудал нь ялын үндсэн зорилго болон хэрэгжиж байгаагийн илрэл юм¹⁰.

Монгол Улс дахь хорих ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдал:

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийг ардын хувьсгал ялж, анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах ажлыг эхлүүлсэн 1921 оноос хойш тооцож үзвэл, 1926, 1929, 1934 оны “Шүүх цаазын бичиг”, 1942, 1961, 1986, 2002 оны “Эрүүгийн хууль”-иуд нь залгамж чанартай, тухайн цаг үеийн улс төр, үзэл суртлыг агуулсан шинжтэй байсан хэдий ч түүхэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж иржээ.

Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилтэй уялдан Монгол Улсад хорих ял эдлүүлэх ажиллагааг 1931 он /Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн, ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль/, 1966 он /Засан хүмүүжүүлэх хууль/, 1981 он /Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль/, 1993 он /Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль/, 1996 он /Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль/, 2002 он /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль/, 2017 он /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай/ хуулиудын хүрээнд зохицуулж иржээ.

Монгол Улс хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилгоо:

- 1920-1940 он хүртэл “хэрэгтэн, ялтныг засан хүмүүжүүлэхэд хоригдогсдын биеийг элдвээр зовоох, доромжлох, жанчих, гар хөлийг хүлэх, харанхуй газар хорих, хоол ундыг хасах, ганцаар хорьж хэрхэвч үл болно”,

- 1940-1970 он хүртэл “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ялыг хууль ёсоор эдлүүлж, тэднийг хууль ёсыг хүндэтгэн сахиж, социалист нийгмийн амьдрал, хөдөлмөрт хэвшүүлэн дахин хүмүүжүүлэх, тэднээс шинээр гэмт хэрэг үйлдэх буюу нийгэмд хортойгоор нөлөөлөх явдлаас урьдчилан сэргийлэхэд оршино”

- 1970-1990 он хүртэл “ялтныг үйлдсэн гэмт хэрэг нь цээрлүүлэх төдийгүй, хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд биелүүлдэг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэдэг үзэлтэй болгон засан хүмүүжүүлэх, ялтныг болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн ял эдлэлтийн биелэлтийг хангах, түүнчлэн гэмт хэргийг арилгахад тус дөхөм үзүүлэх явдалд оршино” гэж тунхаглан хэрэгжүүлж ирсэн байна.

- 1990 оноос өнөөг хүртэл хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилгыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгайлан заалгүйгээр Эрүүгийн хуульд заасан ялын зорилго, Хорих байгууллагын чиг үүргээр тодорхойлдог болсон байна.


Монгол Улсад 2003-2019 оны жилийн эцсийн байдлаар ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад хорих ял эдэлсэн хоригдлын тоог авч үзвэл 2003 онд - 5769, 2004 онд - 6341, 2005 онд - 6782, 2006 онд - 5101, 2007 онд - 6109, 2008 онд - 5601, 2009 онд - 4986, 2010 онд - 5694, 2011 онд - 6410, 2012 онд - 6786,

¹⁰ Б.Алтангэрэл.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судлал.УБ.,2018 он.36 дахь тал

2013 онд - 6974, 2014 онд - 6402, 2015 онд - 4480, 2016 онд - 4464, 2017 онд - 2942, 2018 онд - 3525, 2019 онд - 3995 хоригдол ял эдэлсэн байна.

Улсын хэмжээнд жилд дунджаар 6000 орчим хүн хорих ял эдэлж байгаа ба зарим жилүүдэд гарсан өршөөлийн хууль, эрүүгийн хуулийн тэгшитгэлээс шалтгаалан хоригдлын тоо буурсан үзүүлэлтэй байна.

Зураг.2. 2003-2019 оны жилийн эцсийн байдлаар хорих ял эдэлсэн хоригдлын тоон үзүүлэлт



1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан 2002 оны Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн захиалга, шаардлагаар уг хуульд олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулж иржээ. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 7 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийн 2-т “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх, хорих ял эдлүүлэх ажиллагааг олон улсын жишигт нийцсэн нөхцөлд хүргэнэ” зэрэг зорилт дэвшүүлсэн байна¹¹.

Дэлхийн улс орнуудын ял эдлүүлэх ажиллагаандаа баримталж буй үзэл баримтлал нь аль болох хорих ял оногдуулахаас зайлсхийн ялын өөр төрлийг сонгон хорих байгууллагын бөөгнөрлийг багасгах, хоригдлыг ял эдлэх хугацаанд нь нийгэмшүүлэх, ажлын байраар ханган, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэхгүйгээр амьдрах зан төлөв, нийгмийн орчин нөхцөлийг нь бүрдүүлэхэд чиглэгдэж байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааг олон улсын жишигт нийцсэн нөхцөлд хүргэх нь хорих байр, орчин, нөхцлийг бусад оронтой жиших асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд олон улсын гэрээ, конвенцийн хэм хэмжээ, үзэл баримтлалыг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэх, ялын зорилгыг хангахад нийгэмшүүлэх ажиллагааг чиглүүлсэн эрх зүйн зохицуулалт, орчин нөхцөлтэй байхад оршино.

¹¹ Хууль зүйн яам. “Хөгжлийн стратеги /2009-2021/”. УБ., 2009. 38 дахь тал

Монгол Улсад өнөөдрийн байдлаар хорих ял эдлүүлэх дэглэм, хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрхийн актууд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /хорих ял эдлүүлэх чиглэлээрх/-ийн хэрэгжилтэд хийх энэхүү үнэлгээний зорилго нь тус хуулийн хэрэгжилтийн явц дахь хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийн ялгаатай байдал, хоригдлын хуульд заасан үндэслэл, журмын дагуу дэглэм, зэрэглэл буурах, хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажилд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

Дээрх хүрээнд хорих ял эдлүүлэх дэглэмийн шинэчлэлт, ял эдлүүлэх ажиллагааны явц дахь нийгэмшүүлэх ажил хэрхэн явагдаж байгаа, үйл ажиллагааны хөтөлбөрт нийцэж байгаа эсэхийг тогтоох үүднээс хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр судалгааны багаас уг судалгааг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээрх хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улсад хорих ял эдлүүлэх дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудал анх 2006 оноос хойш холбогдох судалгаа, шинжилгээний ажил хийгдэж эхэлсэн ба дараах эрх зүйн зохицуулалтаар баталгаажиг байжээ. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.11-д “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, ялтныг хуульд заасан шаардлага, олон улсын стандарт, жишигт нийцсэн нөхцөлд ял эдлүүлнэ”

2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Хөгжлийн стратеги батлах тухай” 2009 оны 7 дугаар сарын 15-ны тушаалаар баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөрт “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж олон улсын жишигт хүргэх” зорилтыг хэрэгжүүлэх ажиллагааны төлөвлөгөөний 2.2-т “Нээлттэй, хаалттай хорих анги” төсөл хэрэгжүүлэх /2008-2009/, хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай хорих ангийн тогтолцоонд шилжүүлж, олон улсын жишигт хүргэх асуудлыг зарим хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадад /Дархан-Уул/ хэрэгжүүлэхээр тусгасан.

3. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 193 дугаар тогтоолоор “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр”-ийг баталсан.

4. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.4.10-т Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, цагдан хорих байрны нөхцөлийг хүний жам ёсны эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон теле хяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах, иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр

гүйцэтгэлийн зарим ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэтгэнэ зэргээр тусгаж байжээ.

Дээрх баримт бичгүүдтэй уялдан хууль зүй, дотоод хэргийн сайдын болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар ажлын хэсгүүд байгуулагдан холбогдох судалгаа, шинжилгээний ажлыг хийн, гадаад орон руу туршлага судлах, хуулийн төсөл боловсруулах зэргээр ажиллаж байсан байна.

Бараг 90 гаруй жил хэрэгжиж ирсэн жирийн, чанга, онцгой дэглэм болон гянданг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудал харьцангуй онолын болон практик хэрэгжилтийн хувьд хүндрэлтэй байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Аливаа хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлахад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд асар их цаг хугацаа, хөдөлмөр шаардагдана. Учир нь тус хуулиар эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн зэрэг шийдвэр гүйцэтгэлийн олон талт харилцааг бүхэлд нь зохицуулсан байх тул зөвхөн эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа түүн дотроо ялын зорилгыг хангахад чухал нөлөө үзүүлэх зарим зохицуулалтыг тусгайлан сонгож үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй гэж үзлээ.

Шинэчлэн найруулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр туссан онцлох зохицуулалт нь хорих ял эдлүүлэх байгууллагын тогтолцоо, ял эдлүүлэх төрөл, дэглэмийг шинэчлэн, хоригдлыг нийгэмшүүлэх асуудлыг шинэчлэн тодорхойлсон явдал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195.1-д “хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ”, 198.1-д “нээлттэй хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна”, 199.1-д “хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна, тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна”, 218.1-д “хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ” зэрэг зохицуулалтын хүрээнд зохих судалгааг хийж гүйцэтгэлээ.

Өөрөөр хэлбэл энэхүү судалгаагаар хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийн ялгаа, онцлог, дэглэм, зэрэглэл буурах нөхцөл, журам болон хоригдлыг нийгэмшүүлэх ажлын хүрээний эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр судалгааны хүрээг тогтоосон болно.

1.3.Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /хорих ял эдлүүлэх ажиллагааны зарим зохицуулалт/ хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

1.3.1.“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлд “эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг **цээрлүүлэх**, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг **сэргээх**, хохирлыг **нөхөн төлүүлэх**, гэмт хэргээс урьдчилан **сэргийлэх**, гэмт хэрэг үйлдсэн хүнийг **нийгэмшүүлэхэд** оршино” хэмээн тодорхойлжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зорилт нь “шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлжээ.

Дээрхээс үзвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь шүүхээс гаргасан бүхий л төрлийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах явдал болох нь харагдаж байна. Иймд энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилгыг хангахтай холбогдуулан тусгасан дараах зүйлүүдийг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

Д/д	Сонгосон зүйл заалт	Зүйл, заалтын агуулга
1.	Хорих ял эдлүүлэх ажиллагаа-1 /дэглэм, зэрэглэлийн эрх зүйн зохицуулалт/	195.1.Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг /цаашид “хорих анги” гэх/, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ. 198.1.Нээлттэй хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна. 199.1.Хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна. Тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна. 201.1.Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ. 202.1.Хорих ял шийтгүүлсэн арван найман насанд хүрсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлнэ. 206.1.Хорих ял эдэлж байгаа хоригдлын ял эдлүүлэх хорих

		<p>ангийн дэглэм, зэрэглэлийг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийн байдлыг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу өөрчилж болно.</p> <p>208.3. Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.</p>
2.	Хорих ял эдлүүлэх ажиллагаа-1 /хоригдлыг нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалт/	<p>218.1. Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>218.2. Хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана.</p> <p>218.3. Хорих анги дахь нийгэмшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаас санхүүжүүлж болно.</p> <p>219.1. Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.</p> <p>219.2. Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.</p> <p>219.3. Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна. Нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад хорих анги, алба хаагч, бусад байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд туслалцаа авч болно.</p> <p>219.4. Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн дэглэм, зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.</p> <p>220.1. Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги туслалцаа үзүүлнэ.</p> <p>220.2. Ерөнхий боловсролын сургалтыг хорих ангийн байранд зохион байгуулна.</p> <p>221.1. Хорих анги өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно.</p>

		<p>221.2.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулна.</p> <p>222.1.Хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна.</p>
--	--	--

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

Хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийн эрх зүйн зохицуулалтын болон хоригдлын дунд явуулах нийгэмшүүлэх ажлын эрх зүйн зохицуулалт нь ял эдлүүлэх ажиллагааны тулгамдаж буй асуудлуудын нэгд зүй ёсоор тооцогдож байна.

Учир нь хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн нөхцөл нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тодорхой дэглэм, нөхцөл журамд хорьж нийгэмшүүлэх асуудал тул дээрх харилцааг нарийвчлан зохицуулах зайлшгүй шаардлага байна.

Судалгааны энэ хэсэгт “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дээрх харилцааны зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонголоо. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас сонгон авсан зохицуулалтыг өмнөх хууль тогтоомж дахь заалттай харьцуулан авч үзэх хэлбэрийг ашиглана.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсрууллаа.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийн ялгаа, түүнийг өөрчлөх, хоригдлыг тусад нь ял эдлүүлэх зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлын зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийн ялгаа, түүнийг өөрчлөх, хоригдлыг тусад нь ял эдлүүлэх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан хорих ангид явуулах нийгэмшүүлэх ажлын эрх зүйн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл унших, судлах, харьцуулалт хийх, хорих байгууллагын алба хаагчидтай уулзаж ярилцлагын арга хийх, хоригдлоос нийгэмшүүлэх үйл ажиллагаатай холбоотой анкетын судалгаа авах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараах хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

1. Мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийх;

2. Судалгаа авах.

Мэдээлэл цуглуулах хүрээнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох ном сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, журам, зааврыг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Судалгаа авах хүрээнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд хорих байгууллагын алба хаагчдаас ярилцлага хийсэн. Түүнчлэн холбогдох байгууллагаас үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, хорих байгууллагын алба хаагчидтай уулзалт-ярилцлага хийх, хоригдлоос анкетын судалгаа авч, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг хийж гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно. Үүнд:

Хууль

- Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992. № 1.
- Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. № 7.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. № 24.

Судалгааны тайлан, эмхтгэл

- ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны 2015-2019 оны үйл ажиллагааны тайлан.
- ШШГЕГ-ын тоо бүртгэл, судалгааны тасгийн 2015-2019 оны жилийн үйл ажиллагааны тайлан.
- ШШГЕГ-ын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн 2015-2019 оны үйл ажиллагааны тайлан
- ДХИС. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт /2003-2018/ тайлан.

Ном, сурах бичиг, гарын авлага

- Б.Дашзэвэг. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй-1. УБ., 2003.
- Б.Дашзэвэг. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй-2. УБ., 2004.
- С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/. УБ., 2014.
- С.Жанцан. Эрүүгийн хариуцлага. УБ., 2006.
- С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/. УБ., 2011.
- А.Лхагва. Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ., 2013.
- А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2012.
- Р.Оюунбадам. Тусгайлсан сургалт, нийгмийн ажлын уламжлал шинэчлэлийн зарим асуудал. УБ., 2005.
- ШШГЕГ. Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2019.

- Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдал. УБ., 2017.

Сэтгүүл

- ШШГС.Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүлийн 2012-2019 оны 4 дүгээр улирал хүртэлх дугаар.

Докторын зэрэг хамгаалсан бүтээл

- Д.Бадам. Насанд хүрээгүй этгээдэд оногдуулах хорих ял: эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2012.
- Р.Оюунбадам. Монгол улс дахь эмэгтэйчүүдийн хорих ял: онол, арга зүй, практик. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2013.
- Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх ажиллагааны онол, арга зүй. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2015.
- Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох нь. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2017.

Интернет сүлжээн дэх веб сайт

- www.mojha.gov.mn
- www.cd.gov.mn

Холбогдох субъектээс авсан судалгаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар хорих байгууллагын харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн 16 дэд дарга нар болон хорих 421, 409 дүгээр ангийн зэрэг нийт 64 алба хаагчдаас ярилцлага хийх, хорих ял эдэлж буй 476 хоригдлоос анкетын аргаар судалгаа хийн энэхүү судалгааг гүйцэтгэв.

Ярилцлагын арга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодруулахаар ярилцлага хийсэн.

ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийн ялгаатай тал, хоригдол дэглэм, зэрэглэл буурах болон тэднийг тусад нь ял эдлүүлэх, хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой заалтад сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Нэг.Хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийг тогтоосон эрх зүйн зохицуулалтын талаар:

Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлд “эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ. Иймд хорих ял эдлүүлэх ажиллагаа нь дээрх үндсэн зорилгыг хангахад чиглэх учиртай.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хорих ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийн ялгаа, түүнийг өөрчлөх, хоригдлыг тусад нь ял эдлүүлэх зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

195.1.Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг /цаашид “хорих анги” гэх/, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ.

Үнэлгээ:

Өнөөгийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэж нэрлэн зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ гэж заасан.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно.

Хорих ангийн нээлттэй болон хаалттай дэглэмийн гол агуулга нь ялтныг сургах, байнгын тасралтгүй ажлын байраар хангах, ял эдлүүлэх орчин нөхцөлийг хүний эрхийг хангасан стандартын дагуу бүрдүүлэх зэрэг асуудлыг цогц хэлбэрээр шийдвэрлэж, хорих ял эдэлж байгаа хүмүүсийг нийгэмшүүлэхэд чиглэгддэг.

Хүснэгт 2. 2002, 2015 оны Эрүүгийн хуульд туссан хорих ял, түүнийг эдлүүлэхтэй холбоотой хэм хэмжээний харьцуулалт


2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
52.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгахыг хорих ял гэнэ.	5.6 дугаар зүйл.Хорих ял 1.Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих

	байгууллагад байлгахыг хорих ял гэнэ.
52.2.Хорих ялын үндсэн хугацаа нэгээс арван таван жил хүртэл байна. Хорих ялыг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар оногдуулж болно.	3.Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ.
52.4.Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлнэ.	2.Нээлттэй, хаалттай хорих байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно.
52.3.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй.	4.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно.
52.5.Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.	5.Энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ. 6.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн хорин таван жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэнэ. 7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан журмаар ялтныг суллаагүй бол хоёр жил тутам энэ талаар дахин хэлэлцэнэ. 8.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял оногдуулахгүй.
52.6.Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан, анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.	
52.7.Хоёр ба түүнээс дээш удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.	
52.8.Хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтан, хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.	
52.9.Урьд нь хорих ял эдэлж байсан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.	

<p>52.11.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон болон арван найман насанд хүрсний дараа онц хүнд гэмт хэрэгт арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эрэгтэй ялтны хорих ялын заримыг гянданд эдлүүлэхээр шүүх тогтоож болно.</p>	
--	--

Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ.

Зураг 3.Хорих байгууллагын тогтолцооны схем




Нээлттэй хорих анги

Нээлттэй хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна.

Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд анх удаа гэмт хэрэг үйлдэж 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг, тусгай зэрэглэлд 2 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл хаалттай хорих ангиас болон нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс хуульд заасан журмын дагуу нээлттэй хорих ангид үргэлжлүүлэн ял эдлүүлэхээр шилжүүлсэн, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан хоригдлыг ял эдлүүлнэ.

Зураг 4.Нээлттэй хорих ангийн зэрэглэл




Хаалттай хорих анги

Хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна. Тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна.

Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд санаатай гэмт хэрэг анх удаа үйлдэж 4-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хөнгөн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг, тусгай зэрэглэлд 6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлж байсан хоригдлыг ял эдлүүлнэ. Хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлнэ.

Зураг 5. Хаалттай хорих ангийн зэрэглэл



Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнд ял эдлүүлэх

Гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг

сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлэх ба сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр насны эмэгтэй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх тусгай нэгжтэй байна.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулах ба хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэхгүй.

Хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хүнд ял эдлүүлэх

Хорих ял шийтгүүлсэн арван найман насанд хүрсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлнэ.


Эмэгтэйчүүдийн хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна.

- Нээлттэй хорих ангид анх удаа гэмт хэрэг үйлдэж 5 жил хүртэл хугацаагаар ял шийтгүүлсэн, эсхүл болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж 5 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хоригдлыг ял эдлүүлнэ.

- Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд 5 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хорих ял шийтгүүлж байсан хоригдлыг ял эдлүүлнэ.

- Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил, түүнээс дээш хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хүнд гэмт хэрэг хоёр, түүнээс дээш удаа үйлдэж хорих ял шийтгүүлж байсан эмэгтэй хоригдлыг ял эдлүүлнэ.

Зураг 6.Эмэгтэйчүүдэд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх тогтолцоо



Шинээр хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх хорих ангийн зэрэглэлийг тогтооход:

1. Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд анх удаа гэмт хэрэг үйлдэж 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг;

2. Нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд 2 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл хаалттай хорих ангиас болон нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс нээлттэй хорих ангид үргэлжлүүлэн ял эдлүүлэхээр шилжүүлсэн, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан хоригдлыг;

3. Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд санаатай гэмт хэрэг анх удаа үйлдэж 4-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хөнгөн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг;

4. Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлж байсан хоригдлыг;

5. Хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг;

6. Эмэгтэйчүүдийн нээлттэй хорих ангид анх удаа гэмт хэрэг үйлдэж 5 жил хүртэл хугацаагаар ял шийтгүүлсэн, эсхүл болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж 5 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хоригдлыг;

5. Эмэгтэйчүүдийн хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд 5 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хорих ял шийтгүүлж байсан хоригдлыг;

6. Эмэгтэйчүүдийн хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил, түүнээс дээш хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хүнд гэмт хэрэг хоёр, түүнээс дээш удаа үйлдэж хорих ял шийтгүүлж байсан эмэгтэй хоригдлыг тус тус ял эдлүүлнэ зэргээр хуульчилжээ.

Хорих байгууллагын тогтолцооны хувьд 2017 оны хуулийн онцлог нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв гэсэн шинэлэг бүтцийг тусгасанд оршиж байна.

Хүснэгт 3. 2002, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд туссан хорих дэглэм, зэрэглэлийн ялгаанд хийсэн харьцуулалт

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
<i>Тухайн хорих ангид хорих этгээд:</i>	
Жирийн дэглэмтэй хорих ангид: -хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан -онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтан.	Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд: -анх удаа гэмт хэрэг үйлдэж 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн -болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн хоригдол.

	Нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд: -2 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн -хаалттай хорих ангиас болон нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс хуульд заасан журмын дагуу нээлттэй хорих ангид үргэлжлүүлэн ял эдлүүлэхээр шилжүүлсэн, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан хоригдол.
Чанга дэглэмтэй хорих ангид: -хорих ял эдэлж байсан -онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтан.	Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд: -санаатай гэмт хэрэг анх удаа үйлдэж 4-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн -урьд өмнө хөнгөн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хоригдол.
Онцгой дэглэмтэй хорих ангид: -хоёр ба түүнээс дээш удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн -онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтан.	Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд: -6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн -урьд өмнө хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлж байсан хоригдол.
Гянданд: -онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон -арван найман насанд хүрсний дараа онц хүнд гэмт хэрэгт арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эрэгтэй ялтны хорих ялын заримыг.	Хаалттай хорих ангийн тусгай нэгжид: -бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол.
Насанд хүрээгүй ялтны ялыг зөвхөн насанд хүрээгүйчүүдийн хорих ангид эдлүүлнэ.	Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр насны эмэгтэй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх тусгай нэгжтэй байна.
Эмэгтэй ялтны ялыг зөвхөн эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлнэ. Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна.	Хорих ял шийтгүүлсэн арван найман насанд хүрсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлнэ.
Эргэлт, уулзалт:	
Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтан: -илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд жилд найман удаа удаан хугацааны уулзалт хийж болно. - төрөл, садангийнх нь хүн хүндээр өвчилсөн буюу нас барсан, гамшиг болон аюул үүссэний улмаас ар гэрт нь үлэмж хор хөнөөл учирсан бол жирийн дэглэмтэй хорих ангийн ялтанд 7 хүртэл хоногийн чөлөө олгож болно. -Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтан өөрийн зардлаар таксофон ашиглах эрхтэй.	Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол: -30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийх -түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй. -нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын төрөл, садангийн хүн хүндээр өвчилсөн, эсхүл нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсоны улмаас ар гэрт нь үлэмж хор хөнөөл учирсан бол тухайн хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийг харгалзан хорих ангийн дарга зам хоногийг оролцуулан 7 хүртэл хоногийн чөлөө олгоно.
	Нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол: -7 хоногт нэг удаа түр -45 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийх -7 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар

	ярьж болох бөгөөд захидал илгээх тоог хязгаарлахгүй.
<p><i>Чанга дэглэмтэй хорих ангийн ялтан:</i></p> <p>-2 сард нэг удаа түр -3 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж -сард нэг удаа илгээмж авч болно.</p>	<p><i>Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол:</i></p> <p>-60 хоногт нэг удаа түр -90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, -30 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.</p> <p><i>Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол:</i></p> <p>-90 хоногт нэг удаа түр -120 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж -60 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.</p>
<p><i>Онцгой дэглэмтэй хорих ангийн ялтан:</i></p> <p>-жилд 3 удаа түр, 2 удаа удаан хугацааны уулзалт хийх -жилд 3 удаа илгээмж авч -сард 2 удаа захидал явуулж болох бөгөөд ялынхаа тал хувийг эдэлсний дараа жилд 3 удаагийн нэмэлт илгээмж авч болно.</p>	
<p><i>Гяндангийн ялтан:</i></p> <p>-жилд 2 удаа түр уулзалт хийж -1 сард нэг удаа захидал явуулж болно.</p>	<p><i>Хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдол:</i></p> <p>-180 хоногт хоёр удаа түр уулзалт хийж -30 хоногт нэг удаа захидал явуулж -90 хоногт нэг удаа илгээмж авч болно.</p>
<p><i>Насанд хүрээгүй ялтан:</i></p> <p>-илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй -жилд 8-аас дээшгүй удаа удаан хугацааны уулзалт хийж болно. Насанд хүрээгүй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол: -1 сард нэг удаа түр -2 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, сард нэг удаа илгээмж авч болно.</p>	<p><i>Өсвөр насны хоригдол:</i></p> <p>-илгээмж авах, түр уулзалт хийх, утсаар ярих тоог хязгаарлахгүй -15 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болно.</p>
<p><i>Эмэгтэй ялтан:</i></p> <p>-илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй -удаан хугацааны уулзалтыг жилд найман удаа хийж болно. Эмэгтэй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол: -1 сард нэг удаа түр, 2 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж -1 сард нэг удаа илгээмж авч болно.</p>	<p><i>Нээлттэй хорих ангид ял эдэлж буй эмэгтэй хоригдол:</i></p> <p>-илгээмж авах тоог хязгаарлахгүй - 7 хоногт нэг удаа түр -30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж -7 хоногт нэг удаа илгээмж явуулж, утсаар ярьж болно.</p> <p><i>Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй эмэгтэй хоригдол:</i></p> <p>-30 хоногт нэг удаа түр -60 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж -30 хоногт нэг удаа утсаар ярьж -15 хоногт нэг удаа илгээмж авч болно.</p>

	<p>Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй эмэгтэй хоригдол:</p> <p>- 45 хоногт нэг удаа түр -90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж -30 хоногт нэг удаа илгээмж авч -60 хоногт нэг удаа утсаар ярьж болно.</p>
Хоригдлын хөдөлмөр:	
Ялтны хөдөлмөрийг хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэн зохион байгуулна.	Хоригдлын хөдөлмөрийг холбогдох хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэн зохион байгуулна.
Насанд хүрээгүй болон жирийн дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цаг нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.	Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.	Хаалттай хорих ангийн хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.
Ялтнаар ажил хийлгэхдээ түүний мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзах боловч мэргэжлийн ажил байхгүй нь түүнийг хөдөлмөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.	Хоригдлоор ажил хийлгэхдээ түүний мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзах бөгөөд мэргэжлийн ажил байхгүй нь түүнийг хөдөлмөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага өөрийн болон өөрийнхөө хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсхүл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар хөдөлмөрлүүлж болно.	Нээлттэй хорих ангийн хоригдлыг хорих байгууллага өөрийн болон өөрийн хувь нийлүүлсэн, хамтарсан хуулийн этгээдэд, эсхүл бусад хуулийн этгээдтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар хөдөлмөрлүүлж болно.
Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих байрны аж ахуйн үйлчилгээнд ажиллуулж болно.	Нээлттэй хорих ангийн хоригдлыг хүсэлтийг нь үндэслэн хаалттай хорих анги, цагдан хорих байр, хорих эмнэлгийн аж ахуйн үйлчилгээнд хөдөлмөрлүүлж болно.
Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага зөвхөн өөрийн үйлдвэрлэл дээр, харуул хамгаалалттай нөхцөлд хөдөлмөрлүүлнэ.	Хаалттай хорих ангид ял эдэлж байгаа хоригдлыг зөвхөн хорих байгууллагын үйлдвэрлэлд хөдөлмөрлүүлнэ.
Гяндангийн ялтныг зөвхөн гяндангийн байранд хөдөлмөрлүүлж болно.	Хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно.
	Хоригдолд хөдөлмөрийн хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөр хамгааллын тусгай зориулалтын хувцас, хамгаалах хэрэгсэл, шаардлагатай тохиолдолд хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй олгоно.

	<p>Хоригдлын хүсэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй, 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй хоригдлыг бие, эрүүл мэндийн нөхцөлд нь таарсан ажил гүйцэтгүүлж болно.</p> <p>Хорих анги хоригдлыг хөдөлмөрлөх, тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшүүлэх, дадлага олгох тэгш нөхцөл, боломж бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</p> <p>Хоригдлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аж ахуйн ажлаас бусад ажилд хөлс, урамшуулалгүйгээр хөдөлмөрлүүлэхийг хориглоно.</p>
Хоригдлын ангилан хувиарлах ажиллагаа:	
<p>Ялтныг тусад нь ял эдлүүлэх: -Насанд хүрээгүй болон эмэгтэй, эрэгтэй ялтныг тус тусад нь ял эдлүүлнэ. -Ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй, дархлалын олдмол хомсдол өвчнөөр халдварласан, өвчилсөн ялтныг бусад ялтнаас тусгаарлан ял эдлүүлнэ. -Ижил дэглэмтэй хорих ангид анх удаа ял эдэлж байгаа ялтныг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнаас, засарч хүмүүжиж байгаа ялтныг засрал олохгүй байгаа ялтнаас, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн ялтныг тус тусад нь ял эдлүүлнэ.</p>	<p>Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх: -Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны болон эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ. -Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хоригдлыг бусад хоригдлоос тусгаарлан ял эдлүүлнэ. -Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.</p>
<p>Шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 10 хоногийн дотор аймаг, нийслэл дэх жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлэх ялтныг шууд, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданд ял эдлэх ялтныг Дамжин өнгөрүүлэх ангид хүргэнэ.</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь хоригдлыг ял эдлүүлэх хорих ангид нь хүргэх хуяглан хүргэх чиг үүрэг бүхий нэгжтэй байна.</p>
<p>Дамжин өнгөрүүлэх ангид ирсэн ялтан чухам аль ангид ял эдлэхийг Тогтоол гүйцэтгэх газар шийдвэрлэх ба ийнхүү гаргасан хуваарийн дагуу түүнийг ял эдлэх хорих ангид нь хүргэх асуудлыг Дамжин өнгөрүүлэх анги хариуцан гүйцэтгэнэ.</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дэргэд шинээр хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх хорих анги болон хорих ангийн зэрэглэлийг тогтоох чиг үүрэг бүхий зөвлөл ажиллана.</p>
Хорих орчин, нөхцөл	
<p>Ялтныг эрүүл ахуй, ариун цэврийн тусгайлан тогтоосон шаардлага хангасан байр, ахуйн нөхцөлөөр хангана.</p>	<p>Хорих өрөө нь олон улсын стандартад нийцсэн байна.</p>

Хүснэгт 4.Дээрх хоёр хуулийн хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын дүн шинжилгээ хийж үзвэл:

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн үйлчлэлийн давуу тал	2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн үйлчлэлийн сул тал
Хэнийг хаана хорих нь тодорхой байдлаар хуульчилагдсан.	Дэглэмийн ялгаа нь зөвхөн ялтны эргэлт, уулзалтаар хязгаарлагдаж байсан.
Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх асуудлыг тодорхой болгосон.	Ялтны хэрхэн нийгэмшүүлэх эсэх нь тодорхой бус байсан.
2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн үйлчлэлийн давуу тал	2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн үйлчлэлийн сул тал
Нээлттэй, хаалттай хорих байгууллагын тогтолцоог анхлан хуульчилж өгсөн.	Нээлттэй, хаалттай хорих ангийн ялгаа нь мөн эргэлт, уулзалтаар хязгаарлагдах болсон.
Хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийг шийдвэрлэх зөвлөлийг хуульчилж өгсөн.	Материаллаг хууль болох Эрүүгийн хууль тогтоомжтой зарим талаар зөрчилдөх заалтууд хуульчлагдсан. Тухайлбал, бүх насаар хорих ял эдлүүлэх ажиллагаа.
Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах тогтолцоо, арга хэмжээг хуульчилж өгсөн.	Нээлттэй, хаалттай хорих анги нь хорих ял байгууллагын төрөл эсхүл дэглэм эсэх нь тодорхой бус байдлаар хуульчилагдсан.
Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын эрх зүйн үндсийг хуульчилж өгсөн.	Энгийн болон тусгай зэрэглэлийн ялгаа муутайгаас нэг хорих ангид хоригдох, нөхцөлийн хувьд адил байхаар хуульчилагдсан.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшүүлэх үндсэн гол арга нь хорих ял эдлүүлэх дэглэмийн оновчтой тогтолцоо, түүнд тохирсон нөхцөл журмыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байдаг ба Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дэглэм нь төдийлөн ялгаагүй, ялын зорилгыг бүрэн хангахад чиглэхгүй байна.

Шигтгээ 1. Хорих ял эдлүүлэх зэрэглэл нь хоорондоо ялгаагүй байна. Үүнийг үйлдсэн гэмт хэрэг, хоригдлын хувийн онцлогоос нь хамааруулан ялгаатай болгох хэрэгтэй. Түүнчлэн хорих ангийн байр, өрөөний багтаамжаас шалтгаалан зэрэглэл хоорондоо холилдон ял эдлэх явдал түгээмэл байна... алба хаагчидтай хийсэн ярилцлагаас

Дэглэм нь ял эдлэх нөхцөлийн ялгаатай байдал гэж үзвэл хорих орчин нөхцөл, хамгаалалт, нийгэмшүүлэх ажилд хамрагдах байдал, эргэлт уулзалт, эрхийн хязгаарлалт, хөдөлмөрийн нөхцөл зэрэг олон зүйлээр ялгагдаж байх ёстой байна.

Хоёр.Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалтын талаар:

208.1.Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны болон эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.
 208.2.Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хоригдлыг бусад хоригдлоос тусгаарлан ял эдлүүлнэ.
 208.3.Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ

төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.

Үнэлгээ:

Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх тухай асуудал нь нэг хоригдолд илүү нөхцөл, журамд хорих тухай асуудал биш бөгөөд тухайн хоригдлын нас, хүйс, үйлдсэн гэмт хэрэг, хувийн онцлогыг нь харгалзан бусад хоригдлоос тусгаарлах тухай ойлголт юм.

Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх талаарх хэм хэмжээ	Олон улсын эрх зүйн баримт бичиг	Үндэсний хууль тогтоомж дахь зүйл заалт
	Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм 8 дугаар зүйл	ШШГТухай хуулийн 208 зүйл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар дараах үндэслэлээр хоригдлыг тусад нь ял эдлүүлж байна. Үүнд:

1. Өсвөр насны хоригдлыг насанд хүрэгчдээс;
2. Эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тусад нь;
3. Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хоригдлыг бусад хоригдлоос тусгаарлан;
4. Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос;
5. Засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос;
6. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос;
7. Эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.

Шигтгээ 2. Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд 130 гаруй хар тамхитай холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд нэг хорих ангид 10-20 хоригдол ял эдэлж байгаа нь тухайн төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг тус тусад нь хорих ямар ч бололцоогүй байна.алба хаагчидтай хийсэн ярилцлагаас

Гурав.Хоригдлыг дэглэм, зэрэглэл бууруулах эрх зүйн зохицуулалтын талаар:

206.1.Хорих ял эдэлж байгаа хоригдлын ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийн байдлыг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу өөрчилж болно.

206.2.Хорих ангийн дэглэмийг өөрчлөх асуудлыг энэ хуулийн 224.2-т заасан зөвлөл саналаа прокурорт гаргаж, прокурор үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт үйлдэн шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлэх бөгөөд хорих ангийн зэрэглэлийг өөрчлөх асуудлыг энэ хуулийн 224.2-т заасан зөвлөлийн саналыг үндэслэн прокурор шийдвэрлэнэ.

206.3.Хоригдлын ял эдлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих

ангийг солих тухай санал гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

206.4.Энэ хуулийн 206.3-т заасны дагуу шилжүүлэн ял эдлүүлэх хоригдол нь нээлттэй хорих ангийн хуваарилагдсан зэрэглэлд хорих ялын гуравны нэгээс багагүй хувийг эдэлсэн, сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, хаалттай хорих ангийн хуваарилагдсан зэрэглэлд хорих ялын талаас багагүй хувийг эдэлсэн сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй байна.

206.5.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно.

206.6.Энэ хуулийн 206.5-д заасны дагуу шилжүүлэх хоригдол нь сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй байх бөгөөд сүүлийн 1 жилийн дотор сахилгын зөрчил гаргасан тохиолдолд сүүлийн зөрчил гаргасан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрсний дараа шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

206.7.Сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, сахилга, засрал хүмүүжлийн байдлаараа эерэг үнэлгээ авсан нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдлыг хорих ялын хугацаа дуусахаас 1 жилийн өмнө нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлнэ.

206.8.Хоригдол 1 жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд зөвлөл нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, тусгай зэрэглэлээс тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэн шилжүүлэх саналаа прокурорт гаргаж, прокурор 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

206.9.Энэ хуулийн 206.8-д заасны дагуу шилжүүлэн ял эдэлж байгаа хоригдол хуваарилагдсан зэрэглэлд 1 жилийн хугацаанд зөрчил гаргаагүй бол зэрэглэл хүндрүүлэн шилжүүлсэн дарааллын дагуу анх хуваарилсан зэрэглэлд зэрэглэл хөнгөрүүлэн шилжүүлнэ.

206.10.Хоригдлыг 1 жилийн дотор нэгээс илүү удаа зэрэглэл хөнгөрүүлэн шилжүүлэхгүй.

206.11.Энэ хуулийн 206.8-д заасан журмын дагуу нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд шилжүүлсэн хоригдол мөн хэсэгт заасан зөрчлийг давтан гаргасан тохиолдолд энэ хуулийн 206.2-т заасны дагуу хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлэн ял эдлүүлэх саналыг прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор үндэслэлийг хянаж, шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

Үнэлгээ:

Нэг.Хорих ял эдэлж буй өсвөр насны хүний тухайд:

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байсан өсвөр насны хүн арван найман насанд хүрсэн бол шүүхээс:

1.Эдлээгүй үлдсэн хорих ялыг хорин нэгэн нас хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх

2.Эсхүл насанд хүрэгчдийн хорих байгууллагад шилжүүлэн эдлүүлэх эсэхийг асуудлыг шийдвэрлэдэг.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга өсвөр насны хоригдол арван найман насанд хүрсэн тохиолдолд ялыг нь хорих ангид шилжүүлэн эдлүүлэх эсэх асуудлаар хоригдлыг арван найман насанд хүрэхээс 3 сарын өмнө прокурорт санал гаргах бөгөөд прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Шүүх хоригдлын эдлээгүй үлдсэн ялын хугацаа 2 жилээс илүүгүй тохиолдолд түүний хувийн байдал, төлөвшлийг харгалзан сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын даргын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ялын хугацааг дуусах хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн ял эдлүүлж болно.

Хоёр. Бүх насаар хорих ял шийтгэгдсэн этгээдийн тухайд:

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн хорин таван жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэх ба ялтныг суллаагүй бол хоёр жил тутам энэ талаар дахин хэлэлцэнэ.

Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болох ба шилжүүлэх хоригдол нь сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, сүүлийн 1 жилийн дотор сахилгын зөрчил гаргасан тохиолдолд сүүлийн зөрчил гаргасан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрсний дараа шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Гурав. Нээлттэй, хаалттай хорих ангийн энгийн, тусгай зэрэглэлд хоригдож буй этгээдийн тухайд:

Хорих ял эдэлж байгаа хоригдлын ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийн байдлыг харгалзан хуульд заасан үндэслэл, журмын дагуу өөрчилж болно.

Хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх асуудлыг дараах нөхцлөөр шийдвэрлэнэ. Үүнд:

1. Хорих ангийн дэглэмийг өөрчлөх асуудлыг хоригдлыг ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай санал гаргах чиг үүрэг бүхий зөвлөл саналаа прокурорт гаргаж, прокурор үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт үйлдэн шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

2. Хорих ангийн зэрэглэлийг өөрчлөх асуудлыг зөвлөлийн саналыг үндэслэн прокурор шийдвэрлэнэ.

3. Шилжүүлэн ял эдлүүлэх хоригдол нь нээлттэй хорих ангийн хуваарилагдсан зэрэглэлд хорих ялын гуравны нэгээс багагүй хувийг эдэлсэн, сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, хаалттай хорих ангийн хуваарилагдсан зэрэглэлд хорих ялын талаас багагүй хувийг эдэлсэн сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй байна.

4. Сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, сахилга, засрал хүмүүжлийн байдлаараа эерэг үнэлгээ авсан нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдлыг хорих ялын хугацаа дуусахаас 1 жилийн өмнө нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлнэ.

5. Хоригдол 1 жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд зөвлөл нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, тусгай зэрэглэлээс тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэн шилжүүлэх саналаа прокурорт гаргаж, прокурор 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

6. Хүндрүүлэн шилжүүлэн ял эдэлж байгаа хоригдол хуваарилагдсан зэрэглэлд 1 жилийн хугацаанд зөрчил гаргаагүй бол зэрэглэл хүндрүүлэн шилжүүлсэн дарааллын дагуу анх хуваарилсан зэрэглэлд зэрэглэл хөнгөрүүлэн шилжүүлнэ.

7. Хоригдлыг 1 жилийн дотор нэгээс илүү удаа зэрэглэл хөнгөрүүлэн шилжүүлэхгүй.

8. Хүндрүүлэн шилжин нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд шилжүүлсэн хоригдол зөрчлийг давтан гаргасан тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлэн ял эдлүүлэх саналыг прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор үндэслэлийг хянаж, шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

Шигтгээ 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199.3-т заасан хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлнэ гэх мэтчилэн заасан нь тусгай нэгж нь хаалттай хорих ангийн төрөл, дэглэм, зэрэглэл эсэх нь тодорхой бус байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206.5-д Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно гэж заасан нь шууд зөрчилдөөнийг харуулж байна. Энд тодруулахад тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийн байдлыг харгалзан эхэлж хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд, дараа нь энгийн зэрэглэлд шилжүүлэх зохицуулалтыг хийх хэрэгтэй ..дугаар хорих ангийн алба хаагч ...Б

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлын зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

218.1.Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

Үнэлгээ:

Хоригдлыг нийгэмшүүлэх асуудал нь хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад болон ял эдлээд суллагдсаны дараа гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гэмт зуршлаас нь татгалзуулах, хуулиа сахидаг (law binding) иргэншсэн бие хүн болон төлөвшүүлэх, нийгмийн амьдралд буцаан нэгтгэхэд чиглэсэн сэтгэл зүй, нийгмийн ажил, эрх зүй, менежментийн цогц арга хэмжээгэж ойлгож болно¹².

¹² Г.Баттулга. “Хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлж буй олон улсын туршлага” “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний урлын эмхэтгэл, 2016 он, 8 дахь тал

Хорих байгууллагад явуулах нийгмийн ажлын үйлчилгээ нь хорих байгууллагын зүгээс хоригдолд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг үе шаттай, үр дүнтэй явуулснаар тэднийг нийгэмшүүлэх буюу нийгэмд нь эргэн нэгтгэх (resocialization, reintegration into society), суллагдахаас өмнө эрх чөлөөт амьдралд нь бэлтгэх, суллагдаж гараад дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэн явагддаг.

Үүнийг онолын үүднээс тайлбарлавал тусгайлан боловсруулсан хөтөлбөр, сургалтын дагуу тухайн хоригдлын зан байдал, хувийн онцлог, нас хүйс зэрэг онцлогийг харгалзан ялгамжтай явуулдаг нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээгээр дамжин хэрэгжиж байж үр дүн нь гардаг байна.

Онолын хувьд хорих байгууллагад явуулах “нийгэмшүүлэх ажил” гэсэн нэр томъёог нийгмийн ажлын шинжлэх ухааны тогтсон ойлголт болох “нийгмийн ажлын үйлчилгээ” гэж өөрчлөн энэ салбарт хэрэглэвэл уг үйл ажиллагааны агуулга, зорилгод нийцэх юм.

Олон улсын Нийгмийн ажилтны холбооноос гаргасан тодорхойлолтод “нийгмийн ажил” гэдгийг “Нийгмийн ажил нь нийгмийн өөрчлөлтийг дэмжиж, хүмүүсийн харилцаан дахь бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, хүмүүсийн сайн сайхны төлөө тэднийг чадваржуулж эрх чөлөө, боломжийг нь өргөжүүлэх, тэднийг чадваржуулахад туслах мэргэжлийн үйл ажиллагаа” гэжээ.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг “нийгмийн ажилтан” гэдэг мэргэжилтний хувьд “хувь хүн, гэр бүл, бүлэг олон нийтийг хөгжүүлж тэдэнд тохиолдсон бэрхшээлийг даван туулах, нөөц боломжийг нь бодит байдал болгоход нь туслах зорилготой мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг мэргэжилтэн” хэмээн тус тус тодорхойлсон байна.

Харин нийгмийн ажлын үйлчилгээ нь:

-Хүмүүсийн хувийн болон нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд тэдний өөрсдийн боломжийг дээшлүүлэх

-Нийгмийн гишүүн бүр өөрийгөө хөгжүүлэх, нийгэмдээ зохицох, мөн нийгмийн хөгжилд идэвхтэй оролцох, авъяас чадвараа нээх, нэмэгдүүлэхэд нь туслах

-Хүмүүсийн сайн сайхны төлөө үйлчлэх, нийгмийн бодлого үйлчилгээг нийгэм, эдийн засгийн нөөцдөө тулгуурлан хөгжүүлэх үндсэн зорилтыг агуулдаг.

Манай улсын хувьд хорих байгууллага дахь “нийгмийн ажил”, “нийгэмшүүлэх” гэсэн нэр томъёо, ойлголт 2017 онд шинээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /ШШГТХ/ батлагдах хүртэл “салбарын хуульд тусгаагүй” бөгөөд “хорих байгууллага дахь нийгмийн ажил”, “нийгмийн ажилтан” гэсэн бие даасан ажил, мэргэжлийн ойлголт 2003 оноос л манай оронд бүрэлдэн бий болсон байна¹³.

¹³ ШШГЕГ-аас 2003 онд зохион байгуулсан төв, орон нутгийн хорих ангийн дарга, ахуй дэглэмийн байцаагч нарын нэгдсэн зөвөлгөөнөөс “нийгмийн ажилтан” гэсэн нэр томъёог хэрэглэхээр тогтсон.

2017 онд шинээр баталсан ШШГТХ-д анх удаа Нийгэмшүүлэх ажил, Нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт гэсэн тусгай зохицуулалт тусгагдсан. Тухайлбал, уг хуулийн 218 дугаар зүйлийн 218.1-д “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ”. Мөн хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1-д “Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна” гэжээ.

Харин XIX зууны сүүлчээр барууны зарим орнуудад “Forensic social work буюу шүүхийн нийгмийн ажилтнууд” гэсэн ойлголт бий болж шүүхийн төдийгүй хууль зүйн салбарт хүчтэй түрэн орж ирсэн. Ийнхүү хууль зүйн салбарт нийгмийн ажил гэсэн нэр томъёо, үйлчилгээ нэвтэрч эхэлсэн үеэс их сургууль төгссөн нийгмийн ажилтнууд парол (parole office) болон пробацын (probation office) алба, хорих байгууллагад орж ажиллах болжээ¹⁴. Манай хөрш Оросын холбооны улсын хувьд ОХУ-ын Хууль зүйн сайдын 2000 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 41 дүгээр тушаалаар бүх төрлийн хорих байгууллага, урьдчилан хорих байр болон тэдгээрийн салбар нэгжийн бүтэц орон тоог баталсан бөгөөд “хүмүүжлийн ажлын хэлтэс” гэсэн нэрийг “нийгэм-сэтгэл зүйн хэлтэс” хэмээн өөрчилж хорих байгууллагын бүтцэд хамааруулжээ. Ийнхүү ОХУ-ын хорих байгууллагад анх удаа хоригдолтой ажиллах мэргэжлийн нийгмийн ажлын алба байгуулагдсан¹⁵ түүхтэй.

Бусад улсын туршлагаас үзэхэд хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөө боловсруулж, тэднийг нийгэмшүүлэхэд чиглэсэн олон арван хөтөлбөр хэрэгжүүлж ихээхэн туршлага хуримтлуулж байна.

Манай улсын хорих байгууллага дахь нийгмийн ажлын агуулга, зохион байгуулалт, эрх зүйн орчин, үйл ажиллагааг олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн бүрэлдүүлэхэд бусад орны энэ талаар хуримтлуулсан арвин туршлага, алдаа онооноос суралцах нь зохистой юм.

Хүснэгт.5. 2002, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нийгэмшүүлэх ажлын талаар туссан байдал

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
Хорих байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: -ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх; -насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох;	Хорих анги дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: -хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх; -хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох;

¹⁴ Robert L. Barker, Douglas M. Branson. Forensic Social Work. *Legal Aspects of Professional Practice*, 1993. The Haworth Press, Inc., Binghamton, NY. p 2-3

¹⁵ С.А.Лузгин, М.И. Кузнецов, В.Н. Казанцев, Хорих байгууллагын нийгмийн ажил: Сургалтын гарын авлага. Орос хэлнээс орчуулсан Д.Шатарбал. УБ. 2009 он., 89 дэх тал.

<p>-ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгох...</p>	<p>-хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох...</p>
<p>Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт 1.Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад чиглэлээр хүмүүжлийн ажил зохион байгуулна. 2.Хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, буяны болон бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно. 3.Ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач үйл ажиллагааны хэм хэмжээнд сургах зорилгоор ялтны сайн дурын байгууллага ажиллуулж болно.</p>	<p>Нийгэмшүүлэх ажил 1.Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ. 2.Хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана. 3.Хорих анги дахь нийгэмшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаас санхүүжүүлж болно.</p> <p>Нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт 1.Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна. 2.Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно. 3.Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна. Нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад хорих анги, алба хаагч, бусад байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд туслалцаа авч болно. 4.Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг</p>

	хорих ангийн дэглэм, зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.
Хорих анги дахь сургалт 1.Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ. 2.Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна. 3.Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно. 4.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна.	Хорих анги дахь сургалт 1.Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги туслалцаа үзүүлнэ. 2.Ерөнхий боловсролын сургалтыг хорих ангийн байранд зохион байгуулна.
	Хорих анги дахь сургалтын хэлбэр 1.Хорих анги өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно. 2.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулна.
	Хорих анги дахь албадан сургалт Хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /2002,2017/ хуулийн үйлчлэлийн хүрээнд мөрдөгдөж ирсэн нийгмийн ажлын заавраар тухайн ажиллагааг хэрхэн зохицуулж ирсэнийг харьцуулан судалбал:

Хүснэгт 6. Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын зохицуулалт:

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар /2010.11.10/	Нийгмийн ажлын аргачилсан заавар /2018.7.3/
Нийгмийн ажил гэж	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажил нь хоригдогчийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хоригдогчийн нийгмийн харилцаанд тодорхой үүрэг, байр суурьтай оролцох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ, нийгэм, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа юм.	“Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил” гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1 дэх хэсэгт зааснаар хоригдол нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход нь дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ.
Нийгмийн ажилтан гэж	

<p>Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь мэргэжлийн хувьд нийгмийн ажлын боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй эсхүл нийгмийн ажлын чиглэлээр мэргэжлийн болон давтан сургалтанд хамрагдан мэргэшсэн цэргийн албан хаагч байна.</p>	<p>Нийгмийн ажилтан гэж хорих байгууллагын нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй төрийн тусгай албан хаагчийг тус тус ойлгоно.</p>
<p>Хорих ангийн нийгмийн ажлын зохион байгуулалт, чиг үүрэг</p>	
<p>Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хоригдогчийг чадваржуулах, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлган нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэхэд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нараас бүрдсэн баг ажиллуулах ба мэргэжлийн бие даасан үйл ажиллагаатай байхаар зохион байгуулна.</p>	<p>Хорих ангийн нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>1.хорих ангийн дарга, дэд дарга мэргэшсэн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана;</p> <p>2.мэргэшсэн нэгж нь хоригдлын нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж хорих ангийн даргаар батлуулна;</p> <p>3.нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг улирал, хагас бүтэн жилээр, сургалтын үр дүнгийн талаарх тайланг, тоон судалгааг сар бүрийн 25-ны дотор хорих ангийн даргад танилцуулан, энэ зааврын 2.1-д заасан нэгжид хүргүүлнэ;</p> <p>Мэргэшсэн нэгж нь хоригдлын дунд явуулах сургалт, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад тухайн жилд шаардагдах арга хэмжээний зардлын тооцоог гаргаж, хорих ангийн даргаар уламжлуулан шийдвэрлүүлнэ.</p>
<p>Нийгэмшүүлэх ажлын үе шат</p>	
<p>1. Хоригдогчийн нийгмийн болоод сэтгэл зүйн хэрэгцээнд үндэслэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох.</p> <p>2. Хоригдогчид ял эдлэх болон хоригдох явцад тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх.</p> <p>3 Хоригдогчийн хувийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, тэдгээрийг чадваржуулах, хувь хүний давуу тал, нөөц боломжийг нээн хөгжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.</p> <p>4. Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын нөлөөлөл үзүүлэх.</p> <p>5. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хэрэгжүүлэх нийгмийн ажилд хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах,</p> <p>6. Хоригдогчийн хуулиар хориглоогүй</p>	<p>1.Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил.</p> <p>2.Хорих ерөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил.</p> <p>3.Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил.</p>

<p>эрхийг хангах; 7. Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэлзүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх.</p>	
<p>Судалгааны ажил</p>	
<p>Шинээр ирсэн хоригдогчийг дараах чиглэлээр судлана: 1. зан төлөв, 2. биеэ авч яваа байдал, 3. хувийн сэтгэл зүйн онцлог, 4. орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл санааны хямралд орсон эсэх, 5.хувь хүний давуу талууд буюу мэргэжил, боловсрол, спорт, урлагын болон бусад авьяас чадвар, боломжууд, 6.ар гэр, төрөл төрөгсөд, найз нөхөд буюу ойр дотны хүмүүсийн талаар, 7. ажиллаж, амьдарч байсан газар, нутаг орон, 8. урьд нь ял шийтгэл эдэлж байсан тохиолдолд тухайн үеийн ял эдлэлтийн байдал, 9. үйлдсэн гэмт хэргийн байдал. 10. сэтгэцийн эрүүл мэндийн байдал,</p>	<p>Нийгмийн ажилтан өдөр тутмын үйл ажиллагаандаа дараах бүртгэл, судалгааг гаргасан байна. 1. илгээсэн захидлын бүртгэл; 2. өргөдөл, гомдол, санал хүсэлтийн бүртгэл; 3. хоригдлын ар гэртэй уулзсан бүртгэл; 4. номын сангаар үйлчлүүлсэн хоригдлын бүртгэл; 5. сургалт зохион явуулсан бүртгэл; 6. хоригдолтой уулзсан бүртгэл; 7. гэмт хэрэг, нас, мэргэжил, боловсролын судалгаа; 8. хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын судалгаа; 9. хоригдлын гэр бүл, эргэлт уулзалтгүй хоригдлын судалгаа 10. суллагдахын өмнөх хугацаанд сургалтад хамрагдах хоригдлын судалгаа;</p>

3.2. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан хорих ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийн ялгаа, түүнийг өөрчлөх, хоригдлыг тусад нь ял эдлүүлэх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Нэг. Хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195 дугаар зүйлийн 195.1 дэх хэсэгт “Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг /цаашид “хорих анги” гэх/, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ.” гэж заасны дагуу манай улсад хаалттай 7, нээлттэй 7, нээлттэй-хаалттай 4, эмэгтэйчүүдийн 1, Нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг 2, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага 1, цагдан хорих төв 1, орон нутаг дахь цагдан хорих байр 26 үйл ажиллагаа явуулж байна.

Мөн тус хуулийн 195 дугаар зүйлийн 195.2 дахь хэсэгт “Хорих байгууллага нь төвлөрсөн бүтэцтэй байна” гэж заасны дагуу хорих байгууллагын бүтцийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар баталдаг бөгөөд алба бүр байршил, дэглэм, зэрэглэлээс хамааран янз бүр байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн Б/247 дугаар тушаалаар 441 дүгээр нээлттэй хорих ангийн бүтцийг орон тоо, бүтцийг 58 албан хаагчтайгаар шинэчлэн баталсан байна.

Хорих ял эдлүүлэх албаны чиг үүргийг хэрэгжүүлэгч хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэмийн сүүлийн 5 жилийн байдлаар судлаж үзэхэд:

1.Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан байх бөгөөд “Хорих ангийн нутаг дэвсгэрийн байршил, ял эдлүүлэх харьяалал, үйлдвэрлэлийн чиглэлийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 51 дүгээр тогтоол;

2.“Хорих ангийн дэглэм өөрчлөн зохион байгуулах тухай” Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 71 дүгээр тогтоол;

3.“Зарим хорих ангийг өөрчлөн зохион байгуулах тухай” Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 460 дугаар тогтоол;


4.“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 204 дүгээр тогтоолыг тус тус баталжээ.

Хорих байгууллагын тогтолцооны хувьд 2017 оны хуулийн онцлог нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв гэсэн шинэлэг бүтцийг тусгасанд оршиж байна.

Хорих ял эдэлсэн хоригдлуудыг дэглэмийн хувьд авч үзвэл:


1. 2003-2016 оны жилийн эцсийн байдлаар гянданд ял эдэлсэн хоригдлын тоог авч үзвэл 2003 онд-61, 2004 онд-60, 2005 онд-67, 2006 онд-58, 2007 онд-64, 2008 онд-43, 2009 онд-39, 2010 онд-52, 2011 онд-74, 2012 онд-92, 2013 онд-80, 2014 онд-77, 2015 онд-81, 2016 онд-68 хоригдол ял эдэлсэн байна. Харин 2017 оны хуулийн үйлчлэлийн хүрээнд хаалттай хорих ангийн тусгай нэгжид 2017 онд 43, 2018 онд 9 хоригдол, 2019 онд 18 хоригдол ял эдэлсэн байна.

Зураг. 7. 2003-2016 оны хооронд гянданд ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт




2. 2003-2016 оны жилийн эцсийн байдлаар онцгой дэглэмтэй хорих ангид ял эдэлсэн хоригдлын тоог авч үзвэл 2003 онд-203, 2004 онд-334, 2005 онд-469, 2006 онд-680, 2007 онд-869, 2008 онд-154, 2009 онд-186, 2010 онд-203, 2011 онд-210, 2012 онд-206, 2013 онд-255, 2014 онд-300, 2015 онд-270, 2016 онд-247 хоригдол ял эдэлсэн байна.

Зураг.8.2003-2016 оны хооронд онцгой дэглэмтэй хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт




3. 2003-2016 оны жилийн эцсийн байдлаар чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлсэн хоригдлын тоог авч үзвэл 2003 онд-2501, 2004 онд-2519, 2005 онд-2626, 2006 онд-2337, 2007 онд-2404, 2008 онд-2572, 2009 онд-2532, 2010 онд-2455, 2011 онд-2724, 2012 онд-2804, 2013 онд-2776, 2014 онд-2527, 2015 онд-2106, 2016 онд-1852 хоригдол ял эдэлсэн байна.

Зураг.9. 2003-2016 оны хооронд онцгой дэглэмтэй хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт




4. 2003-2016 оны жилийн эцсийн байдлаар жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлсэн хоригдлын тоог авч үзвэл 2003 онд-2635, 2004 онд-3017, 2005 онд-3212, 2006 онд-1794, 2007 онд-2403, 2008 онд-2409, 2009 онд-1896, 2010 онд-2614, 2011 онд-2992, 2012 онд-3214, 2013 онд-3488, 2014 онд-3149, 2015 онд-1800, 2016 онд-2084 хоригдол ял эдэлсэн байна.

Зураг.10.2003-2016 оны хооронд жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт




5. 2003-2019 оны жилийн эцсийн байдлаар эмэгтэйчүүдийн хорих ангид ял эдэлсэн хоригдлын тоог авч үзвэл 2003 онд-247, 2004 онд-279, 2005 онд-313, 2006 онд-223, 2007 онд-300, 2008 онд-362, 2009 онд-321, 2010 онд-351, 2011 онд-383, 2012 онд-403, 2013 онд-345, 2014 онд-315, 2015 онд-216, 2016 онд-208, 2017 онд- 134, 2018 онд-190, 2019 онд-229 хоригдол ял эдэлсэн байна.

Зураг.11.2003-2019 оны хооронд эмэгтэйчүүдийн хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт



6. 2003-2019 оны жилийн эцсийн байдлаар насанд хүрээгүйчүүдийн хорих ангид ял эдэлсэн хоригдлын тоог авч үзвэл 2003 онд-122, 2004 онд-132, 2005 онд-95, 2006 онд-9, 2007 онд-69, 2008 онд-61, 2009 онд-12, 2010 онд-19, 2011 онд-27, 2012 онд-40, 2013 онд-30, 2014 онд-34, 2015 онд-7, 2016 онд-5, 2017 онд 3, 2018 онд-45, 2019 онд- 29 хоригдол ял эдэлсэн байна.

Зураг.12. 2003-2019 оны хооронд насанд хүрээгүйчүүдийн хорих ангид ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт



7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш буюу 2017 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс хойш шинэ хорих ял эдлүүлэх төрөл, дэглэмийн хүрээнд 2017 онд нээлттэй хорих ангид-1330, хаалттай хорих ангид-1475, 2018 онд нээлттэй хорих ангид-1967, хаалттай хорих ангид-1334, 2019 онд нээлттэй хорих ангид-2658, хаалттай хорих ангид-1296 хоригдол ял эдэлсэн байна.

Зураг.13.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /2017 оны үйлчлэлийн хүрээнд нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлсэн хоригдлын судалгаа



"Хорих ял эдлүүлэх дэглэм" гэдгийг нийтлэг агуулгаар нь авч үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үүсч бий болсон эрхийн хязгаарлалт, ял эдлүүлэх нөхцөл, журам, ялтныг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон өөр хоорондоо ялгаа, өвөрмөц байдал бүхий үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээний нийлбэр юм.

Шигтгээ 4. Дэглэм нь ял эдлэх нөхцөлийн ялгаатай байдал гэж үзвэл хорих орчин нөхцөл, хамгаалалт, нийгэмшүүлэх ажилд хамрагдах байдал, эргэлт уулзалт, эрхийн хязгаарлалт, хөдөлмөрийн нөхцөл зэрэг олон зүйлээр ялгагдаж байх ёстой алба хаагчидтай хийсэн уулзалт-ярилцлагаас


Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшүүлэх үндсэн гол арга нь хорих ял эдлүүлэх дэглэмийн оновчтой тогтолцоо, түүнд тохирсон нөхцөл журмыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байдаг ба Монгол Улсад хүчин төгөлдөр

мөрдөгдөж буй дэглэм нь төдийлөн ялгаагүй, ялын зорилгыг бүрэн хангахад чиглэхгүй байна.

Хоёр.Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх хүрээнд:

Сүүлийн 3 жилд буюу 2016 оноос шинэ төрлийн гэмт хэрэг, тухайлбал, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой, авлига, албан тушаалын гэмт хэрэг илт өссөн байна. Зөвхөн 2006 онд хар тамхитай холбоотой 6 гэмт хэрэгт 33 холбогдогч шалгагдан шийтгэгдэж байсан бол 2018 онд 197 гэмт хэрэгт 402 холбогдогч шалгагдсан буюу хэргийн тоо 32 дахин, холбогдогчийн тоо 12 дахин өссөн. Авлигатай тэмцэх газар 2016 онд 459, 2017 онд 654, 2018 онд 953 хүнд мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.

Зураг. 14.Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн үзүүлэлт



Зөвхөн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны байдлаар хар тамхины төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн 132 хоригдол ял эдэлж буй нь тэднийг тусад нь хорих бололцоог хааж байна.

Гурав.Дэглэм, зэрэглэл өөрчлөх хүрээнд:

Шигтгээ 5.Дэглэм, зэрэглэл бууруулах асуудлыг хоригдлыг өргөдөл гаргаснаас хойш 5 хоногийн дотор шийдвэрлэх ёстой, гэвч өргөдлийг прокурор хянаад 7 хонодог, түүнчлэн прокурор зөвхөн дүгнэлт гаргаад шүүх дээр танилцуулах ёстой атал, шууд хасдаг байдал нь хоригдлын эрхийг зөрчиж байна.Зүй нь хорих ангийн тодорхойлолт, прокурорын дүгнэлтийг үндэслээд шүүх л шийддэг хууль, журамтай баймаар.... Хорих ... ангийн алба хаагч Т.

Дэглэм, зэрэглэл бууруулах асуудлыг хорих анги дээр практикт сар болгон шийдвэрлэж буй нь хорих ангийн алба хаагчдийн хувьд хэт их ачааллыг бий болгож байна, тухайлбал нээлттэй хорих ангийн хувьд хоригдол бүр өргөдөл бичдэг, нийгмийн ажилтан өдөр бүр хоригдлын зан байдлын тодорхойлолт бичиж, ангийн дарга, арга зүйн зөвлөлийнхөн 7 хоног бүр хуралдаж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан хорих ангид явуулах нийгэмшүүлэх ажлын эрх зүйн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлыг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Нэг.Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил:

1. хоригдолтой холбоотой анхан шатны мэдээлэл цуглуулах, санал хүсэлтийг авах зорилготой ярилцлага хийнэ;

2. хоригдлоос шаардлагатай үед холбоо барих хоёроос доошгүй хүний утасны дугаарыг авч ар гэрт нь мэдэгдэх хуудсанд тэмдэглэн мэдэгдэнэ;

3. хоригдлын биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан үүсэх хүндрэлийн талаар хорих ангийн эмчийн тодорхойлолтыг авах;

4. хоригдолд зөвшөөрөх, хориглох эд зүйл, хорих ангийн дотоод цагийн хуваарь, зайлшгүй анхаарах, мэдвэл зохих асуудлын талаар тайлбарлан өгч гарын үсэг зуруулан баталгаажуулна;

5. хоригдолтой анхны уулзалт хийхийн өмнө хувийн хэрэг, холбогдох материалтай биечлэн танилцаж шаардлагатай мэдээллийг цуглуулсны дараа уулзалтын зорилгыг тодорхойлон ярилцах зүйлсийн агуулга, уулзалтын үед ашиглах асуулт зэргийг урьдчилан бэлтгэж төлөвлөгөө гаргана;

6. ерөнхий мэдээллийг маягтын дагуу, ярилцлагын аргаар авч, дэлгэрэнгүй хөтөлнө. Анхны уулзалтаар судалгааг авснаас хойш өөрчлөлт орсон тохиолдол бүрт тэмдэглэл хийнэ;

7. хорих ял эдлүүлэх ажиллагаатай холбогдох зайлшгүй анхаарах, мэдвэл зохих асуудлын талаар хоригдолд танилцуулж анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион явуулна;

8. хоригдлын хувийн онцлог, аливаа зүйлд хандах хандлага, ар гэрийн харилцаа холбоо, орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл зүйд өөрчлөлт байгаа эсэхэд дүгнэлт хийж ангийн удирдлагад танилцуулна;

9. иргэний цахим үнэмлэхний хуулбаргүй хоригдлын талаар мэдээллийг ангийн даргад танилцуулан холбогдох байгууллагуудад албан бичгээр хандаж лавлагааг авна;

Хоёр. Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил

1. хоригдлыг хорих өрөөнд хуваарилах саналыг хоригдлын хувийн онцлогыг харгалзан хорих ангийн даргад танилцуулна.

2. хоригдлыг нийгэмшүүлэх ажилд идэвхтэй үүрэг, хариуцлагатайгаар оролцуулах зорилгоор “Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулах ба гэрээнд нийгмийн ажилтан болон хоригдлын үүрэг, оролцоо, хувийн болон гэр бүлийн нууцыг хадгалах асуудлыг тусгаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3. хорих ангийн дотоод журамд заасны дагуу хоригдол нэг бүрт нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллана.

4. хоригдолд албадан сургалтаас бусад сургалтад хамрагдах тухай санал болгох хуудсыг танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулна.

5. хоригдлын нас, эрүүл мэнд, ажлын дадлага туршлага, мэргэжил, хөдөлмөр эрхлэх хүсэл, сонирхлыг харгалзан ажлын байр санал болгох хуудсыг танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулна.

6. хоригдлын талаарх шаардлагатай мэдээлэл авах, үйлчилгээг үзүүлэх зорилгоор хорих ангийн алба хаагчидтай холбон зуучлах, буцах хуудсаар харилцана.

7. хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийг маягтын дагуу тодорхойлно.

8. шаардлага хангасан хоригдлын хүсэлтийг сар бүрийн сүүлийн 7 хоногт багтаан хүлээн авч бүртгэн, хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийн тодорхойлолт, хоригдлыг шагналын хоног олгуулах санал зэргийг арга зүйн зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлэх.

9. хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настан хоригдлын урьд олгогдож байсан тэтгэвэр, тэтгэмжийг үргэлжлүүлэн авах, шинээр тогтоолгох, протез, ортопедийн хэрэгслийг авах, засварлах, солих зэрэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор хорих ангийн эмч, холбогдох албан тушаалтан байгууллага, иргэнд холбон зуучлах.

10. иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хоригдлыг харьяалах иргэний бүртгэлийн байгууллагатай хамтран бичиг баримтжуулна.

11. хоригдлын урлаг, спортын авьяас, чадварыг нээн хөгжүүлэх болон бусад нийгмийн ажлын үйл ажиллагааг нийгмийн ажилтан нь дангаар буюу төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

12. гэмт хэргийн хор уршгийг таниулах, нийгэмд учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт, хөдөлмөрт хамрагдахын ач холбогдол, хуулиар олгогдсон эрх зүйн боломжийн талаар яриа таниулга хийнэ.

13. хоригдлын хууль, тогтоомжоор хориглоогүй зарим эрх буюу иргэний эрх зүйн харилцаанд оролцох боломжоор хангахад эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх, хууль эрх зүй, танин мэдэхүй, гарын авлага, зөвлөмж, шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.

14. нийгмийн ажилтан хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийг тодорхойлон хорих ангийн даргад танилцуулна.

Гурав. Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил

1. ялын хугацаа дуусч, хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах хоригдлыг нийгмийн амьдралд гарахад нь бэлтгэх зорилгоор 3 сарын өмнө сургалтад хамруулах;

2. нийгмийн амьдралын болон цаг үеийн мэдээллийг гарын авлага, тусгайлан бэлтгэгдсэн нэвтрүүлэг бусад хэлбэрээр танилцуулах;

3. мэргэжлийн болон бусад сургалтад хамрагдсан бичиг баримтыг бүрдүүлэх;

4. хоригдлын гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх;


5. суллагдсаны дараа хүлээн авах орчингүй хоригдлыг халамжийн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагад, хөдөлмөр эрхлэх

хүсэлтэй хоригдлыг хөдөлмөрийн бирж, хөдөлмөр эрхлэх газарт холбон зуучлах зэрэг ажлыг хийж гүйцэтгэдэг байна.

Хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлын үр нөлөөний талаар 476 хоригдлоос социологийн судалгаа авч, дүнг нэгтгэлээ. Үүнд:


1. Судалгаанд хамрагдсдийг насаар ангилан үзвэл 18-25 насныхан 34 буюу 7 хувь, 25-35 насныхан 117 буюу 25 хувь, 35-40 насныхан 96 буюу 20 хувь, 40-45 насныхан 51 буюу 11 хувь, 45-50 насныхан 96 буюу 20 хувь, 50-аас дээш насныхан 82 буюу 17 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 15. Судалгаанд оролцогчдийн насны байдал




2. Судалгаанд хамрагдагсдыг эзэмшсэн боловсролын түвшингээр ангилбал 37 буюу 8 хувь нь боловсролгүй, 68 буюу 14 хувь нь бага, 129 буюу 27 хувь нь бүрэн бус дунд, 151 буюу 32 хувь бүрэн дунд, 38 буюу 8 хувь нь тусгай дунд, 53 буюу 11 хувь нь дээд боловсрол эзэмшчээ.

Зураг 16. Судалгаанд оролцогчдийн боловсролын судалгаа




3. Нийт судалгаанд хамрагдагсдын 246 буюу 52 хувь нь ямар нэг мэргэжил эзэмшсэн, 230 буюу 48 хувь нь огт мэргэжилгүй байна.

Зураг 17. Судалгаанд оролцогчдийн мэргэжилтэй эсэх судалгаа



Хоригдлуудыг эзэмшсэн мэргэжлээр нь ангилбал: жолооч 30, цахилгаанчин 25, гагнуурчин, барилгын засалчин тус бүр 1, инженер, слесар тус бүр 12, хүнд машин, механизмын оператор 11, тогооч 10, автын засварчин 8, нягтлан бодогч, эдийн засагч, оёдолчин тус бүр 7, тоног төхөөрөмжийн засварчин, техникч тус бүр 6, өрөг угсрагч, мужаан, арматурчин, багш тус бүр 5, эрх зүйч, менежер, мэдээлэл холбоо тус бүр 4, ерөнхий цэрэг, геологич, гар утасны засварчин тус бүр 3, барилгын модон эдлэлийн технологич, замчин, дархан, гуталчин, гоо сайханч тус бүр 2, хүний нөөцийн удирдлага, төлөвлөгөөт эдийн засаг, арьсан эдлэлийн зохион бүтээгч, малын эмч, сантехникийн мастер, арга зүйч, тэсэлгээчин, технологич, хөгжимчин, эмч, архитектур, зураглаач, механикч, орчуулагч, удирдлагын ухаан, гидромеханик, ноос, ноолуур боловсруулагч, эрүүл ахуйч, ээрмэлийн технологич тус бүр 1 байна.


Зураг 18. Судалгаанд оролцогчдийн мэргэжлийн судалгаа



4. Ял эдлэхээс өмнө ажил хөдөлмөр эрхэлж байсан эсэх


Судалгаанд хамрагдагсдын 351 буюу 74 хувь гэмт хэрэг үйлдэн, ял шийтгэгдэхээс өмнө хөдөлмөр эрхэлж байсан бол 125 буюу 26 хувь хөдөлмөр эрхэлж байгаагүй байх ба хөдөлмөр эрхлэгсдын 128 нь хувиараа, 78 нь малчин, 55 нь аж ахуйн нэгж, байгууллагад, 30 нь барилгад, 21 нь жолооч, 16 нь төрийн албанд 10 уул уурхайн салбарт, 5 нь хүнсний үйлдвэрт ажиллаж байжээ.

Зураг 19. Судалгаанд оролцогчдийн ажил, хөдөлмөр эрхэлж байсан эсэх судалгаа




5. Гэр бүлийн байдлыг авч үзвэл судалгаанд хамрагдагсдын 40,5% буюу 193 нь гэрлэсэн, 25,8% буюу 123 нь гэрлээгүй, 20,5% буюу 98 нь салсан, 4,2% буюу 20 нь бэлбэсэн, 8,8% буюу 42 нь хамтран амьдрагчтай байна. Мөн судалгаанд хамрагдсан хоригдлуудын 320 буюу 67,2% нь хүүхэдтэй, 156 буюу 32,7% нь хүүхэдгүй байна.

Зураг 20. Судалгаанд оролцогчдийн гэр бүлийн судалгаа




6. Судалгаанд хамрагдагсдын 296 нь буюу 62 хувь нь анх удаа, 81 буюу 17 хувь нь 2 удаа, 52 буюу 11 хувь нь 3 удаа, 47 буюу 10 хувь нь 4 ба түүнээс дээш удаа ял шийтгэгджээ.

Зураг 21. Судалгаанд оролцогчдийн урьд гэмт хэрэг үйлдэж байсан эсэх судалгаа




7. Хорих ангид хоригдож буй хугацаагаар нь харьцуулбал 165 буюу 35 хувь нь 1-5, 152 буюу 32 хувь нь 5-10 жил, 80 буюу 17 хувь 10-15 жил, 77 буюу 16 хувь нь 15-20 жил, 2 буюу 0.4 хувь нь 20-оос дээш жил хорих ял эдэлжээ.

Зураг 22. Судалгаанд оролцогчдийн хорих ангид ял эдэлсэн хугацааны судалгаа




Зураг 23. Судалгаанд оролцогчдийн уулзалт авдаг эсэх судалгаа



8. “Хорих ангиас таньд чиглэсэн ямар арга хэмжээ зохион байгуулаасай гэж боддог вэ?” гэсэн асуултад 131 буюу 28 хувь нь нийгэм, сэтгэл зүйн, 29 буюу 6 хувь нь биеийн тамир, эрүүл мэндийн, 10 буюу 2 хувь нь танин мэдэхүйн, 9 буюу 2 хувь нь урлагийн, 6 буюу 1 хувь нь хүн тус бүрийн хүсэл сонирхлыг харгалзсан, 4 буюу 1 хувь нь цахим сургалт явуулах, 17 буюу 4 хувь хууль, эрх зүйн, 4 буюу 1 хувь нь ерөнхий боловсролын, 63 буюу 13 хувь нь мэргэжил эзэмшүүлэх, 2 буюу 0.5 хувь нь дээд боловсрол олгох, 21 буюу 4 хувь нь гадаад хэлний, 4 буюу 1 хувь нь уулзалт семинар зохион байгуулах, 176 буюу 37 хувь нь одоо зохион байгуулагдаж буй сургалтууд хангалттай гэж үзсэн байна.


9. “Хорих ангиас ямар төрлийн сургалтыг түлхүү зохиовол илүү үр дүнтэй гэж бодож байна” гэсэн асуултад 48 буюу 10 хувь нь гадаад хэлний, 179 буюу 38 хувь нь мэргэжил эзэмшүүлэх, 95 буюу 20 хувь нь хууль, эрх зүйн, 133 буюу 28 хувь нь боловсрол эзэмшүүлэх, 5 буюу 1 хувь нь бусад гэж хариулсан бол 16 буюу 3 хувь бүх төрлийн сургалтад хамрагдаж хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ.

Зураг 24. Судалгаанд оролцогчдийн сургалтын хэрэгцээний судалгаа




10. “Сургалтыг ямар хэлбэрээр явуулбал үр дүнтэй гэж үзэж байна” гэсэн асуултад 120 буюу 25 хувь нь бүх хоригдлыг хамруулж, 164 буюу 35 хувь хоригдлын хүсэл зоригийг харгалзаж, 182 буюу 38 хувь нь сургалтын мэргэшлийн байгууллага, багш нарын тусламжтайгаар, 10 буюу 2 хувь бусад хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй гэж үзжээ.

Зураг 25. Сургалтын хэлбэрийн судалгаа



11. “Суллагдан гараад ямар хөдөлмөр эрхлэх вэ” гэсэн асуултад 117 буюу 25 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлнэ, 64 буюу 13 хувь нь өөрт тохирсон ажлыг ямар ч бай хамаагүй гололгүй хийнэ, 88 буюу 18 хувь нь мал маллана, 19 буюу 4 хувь нь барилга дээр, 57 буюу 12 хувь нь мэргэжлээрээ, 24 буюу 5 хувь гар урлал буюу дархан, мужааны чиглэлээр, 5 буюу 1 хувь нь оёдолчноор, 8 буюу 2 хувь нь уул, уурхайн салбарт, 9 буюу 2 хувь нь жолоочоор, 1 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад 2 буюу 1 хувь нь аялал жуулчлалын салбарт, 2 буюу 1 хувь нь орчуулагчаар ажиллах хүсэлтэй байх ба 8 буюу 2 хувь нь тэтгэвэрт гарах, 11 буюу 2 хувь нь гадаад оронд ажиллаж амьдрах, 8 буюу 2 хувь нь суралцана гэдгээ илэрхийлжээ.

Зураг 26. Суллагдсаны дараа хийх зүйлийн судалгаа



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны гүйцэтгэх үндсэн чиг үүрэгт хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, дахин нийгэмшүүлэх, мэргэжлийн боловсрол, холбогдох сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох чиглэлээр санал боловсруулан хэрэгжүүлэх асуудлыг тусгасан байдаг. Харин шүүхээс оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх чиг үүрэг бүхий хорих анги нь хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох, хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох үйл ажиллагааг явуулах үүрэгтэйг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль¹⁶-д тусгажээ.

Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ба хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана. Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна.

¹⁶ Төрийн мэдээлэл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он. №24

Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.


Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн дэглэм, зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.

Хорих анги дахь ерөнхий боловсролын сургалт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги туслалцаа үзүүлэн сургалтыг хорих ангийн байранд зохион байгуулахаар хуульчилжээ.


Бүрэн дунд боловсрол олгох сургалтад 2012 онд-9, 2013 онд-30, 2014 онд-21, 2015 онд-21, 2016 онд-53, 2017 онд-72, 2018 онд-73 хоригдол хамрагдсан байна.

Зураг 27.2012-2018 оны хооронд бүрэн дунд боловсрол олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт



Бичиг үсгийн сургалтад 2012 онд-278, 2013 онд-223, 2014 онд-276, 2015 онд-287, 2016 онд-235, 2017 онд-214, 2018 онд-89 хоригдол хамрагдсан байна.

Зураг 28. 2012-2018 оны хооронд бичиг үсгийн сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт




2019 оны эхний хагас жилийн байдлаар бичиг үсэг үл мэдэгч болон бага боловсролтой 468 хоригдол ял эдэлж байснаас Насан туршийн боловсролын төв, Ажилчин залуучуудын ээлжийн сургуультай хамтран 117 хоригдолд ерөнхий боловсрол олгох сургалтад хамруулж, хорих ангийн нийгмийн ажилтнууд бусад байгууллагатай хамтарч 336 хоригдолд бичиг үсэг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулсан байна¹⁷.

Хорих анги дахь мэргэжил эзэмшүүлэх сургалт:

Хорих анги өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно. Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулдаг. Мэргэжлийн дадлага олгох сургалтад 2012 онд-125, 2013 онд-409, 2014 онд-659, 2015 онд-1250, 2016 онд-595, 2017 онд-783, 2018 онд-755 хоригдол хамрагдсан байна.

Зураг 29. 2012-2018 оны хооронд мэргэжлийн дадлага олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт



2019 оны эхний хагас жилийн байдлаар мэргэжлийн боловсрол олгох сургалтын онолын сургалтад 177 суралцагч хамрагдаж амжилттай шалгагдсан 86.5 хувь буюу 153 суралцагчийг үйлдвэрлэлийн дадлагад шилжүүлэн хоёрдугаар ээлжийн мэргэжлийн боловсрол олгох онолын сургалтад хамрагдаж байгаа 160, нийт 313 суралцагчийг мэргэжлийн боловсрол олгох сургалтад хамруулж


¹⁷ ХЯЭА-ны Нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн 2019 оны эхний хагас жилийн тайлан

байна.Түүнчлэн аймаг, орон нутгийн Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллежтой хамтран 190 хоригдлыг мэргэжлийн боловсрол олгох сургалтад хамруулан ажиллажээ.

Хорих анги дахь дээд боловсрол олгох сургалт:

Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдол хорих ялын 50-иас доошгүй хувийг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй бөгөөд их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад суралцах хүсэлт гаргасан бол хорих ангийн даргын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга шийдвэрлэх ба сургалтыг хорих ангийн байранд явуулна. Дээд боловсрол олгох сургалтад 2012 онд-2, 2013 онд-5, 2014 онд-5, 2015 онд-6, 2016 онд-0, 2017 онд-0, 2018 онд-0 хоригдол хамрагдсан байна¹⁸.

Зураг 30. 2012-2018 оны хооронд дээд боловсрол олгох сургалтад хамрагдсан хоригдлын үзүүлэлт



2017 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шинээр орсон заалт нь хорих анги дахь албадан сургалтын тухай асуудал бөгөөд монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулахаар заажээ.

Хоригдлын сурах идэвхи, санаачилгыг дэмжих, нөхцөл бололцоог хангах зорилгоор хоригдол чөлөөт цагт шашны зан үйл үйлдэх, хорих ангийн боломж нөхцөл, харуул хамгаалалтын нөхцөл, шаардлага, зэрэглэлд тохирсон спортын сонирхсон төрлөөр хичээллэх, ном, сонин унших, суралцах, хорих ангийн номын санг ашиглах боломжоор хорих анги хангана, хорих ял эдлэх хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, хуваарилсан ажил, үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэсэн, сургалт-хүмүүжлийн ажил болон нийгэмшүүлэх хөтөлбөрт идэвхтэй хамрагдсан, хууль тогтоомж, хорих ангийн дотоод журмыг мөрдөж байгаа байдал, өөрийн зан үйл, хувийн байдлаараа хорих ангийн дарга, алба хаагчаас эерэг үнэлгээ авсан тохиолдолд түүнд шагналын хоног олгоно, сахилгын зөрчил гаргаж байгаагүй, хөдөлмөрлөх үүргээ биелүүлж урамшуулал авч, хорих анги дахь сургалт, нийгэмшүүлэх ажилд идэвхтэй оролцож байсан хоригдол Эрүүгийн хуульд заасан тэнсэн суллагдах хугацаанаас 1 жилийн өмнө нээлттэй хорих ангид ял эдлүүлэх

¹⁸ Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.УБ.,2019 он.86 дахь тал

саналыг арга зүйн зөвлөлөөр хэлэлцэж, саналаа прокурорт, прокурор үндэслэлтэй гэж үзвэл шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлнэ зэргээр хуульчилсан байна.

Оросын Холбооны Улсын хорих байгууллагад явуулж буй сургалтын онцлог:

Эрүүгийн гүйцэтгэлийн тогтолцоонд явуулж буй сургалтын талаар ижил төстэй эрх зүйн зохицуулалт бүхий, хөрш улс болох ОХУ-ыг судлан авч үзвэл:

ОХУ-ын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлд: “Тус улсын иргэн бүр боловсрол эзэмших эрхтэй”¹⁹ гэж заасан нь хорих байгууллагад ял эдэлж буй ялтанд нэгэн адил үйлчилж байна. Учир нь тус улсын ялын бодлогын тулгуур зарчмын нэг бол ялтныг засан хүмүүжүүлэх замаар, эргэн нийгэмшүүлэхэд орших бөгөөд хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь боловсрол олгоход чиглэдэг.

Энэ зорилгоор тус улсын хорих байгууллагын харьяа сургууль байгуулж, хорих ялаар шийтгүүлсэн ялтанд зохих мэргэжил, боловсрол олгодог. Энэ төрлийн анхны сургуулийг 1860 онд “Москвагийн Төлөвшүүлэн гэгээрүүлэх, Ажил хөдөлмөр эрхлүүлэх байр”-ыг байгуулсан бөгөөд тус сургуулийн сургалтын хөтөлбөр нь гол төлөв шашны сургааль номлолд суурилан ухуулан сэнхрүүлэх замаар тэдний зан үйл, ёс суртахууныг төлөвшүүлэхэд чиглэж байв. 1920 оноос эхлэн уг чиг хандлага өөрчлөгдөж, улмаар шоронд бичиг үсэг тайлагдаагүй 50 хүртлэх насны ялтанд зориулсан сургууль байгуулах нь зүйтэй гэсэн шийдэлд хүрч, энэ талаар анхны журам боловсруулж, мөрдсөн байна.

1958 онд уг журмыг “ЗХУ-ын ДХЯ-ны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын харьяа Ерөнхий боловсролын сургуулийн ажиллах журам” болгон өөрчилсөн. Энэхүү журмаар ялтан бүр шоронд хоригдож байх хугацаандаа бүрэн дунд боловсрол эзэмших эрхээр хангагджээ. Харин 1980 оны дунд үеэс ЗСБНХУ-ын бүх засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид ерөнхий боловсролын дунд сургуулийг байгуулсан байна.

Өнөөдөр тус улсын “Боловсролын тухай хууль”-д хорих байгууллагын зүгээс эрх чөлөөгөө хасуулах буюу хорих ялаар шийтгүүлсэн ялтанд зохих түвшний боловсрол эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах талаар тусгасан²⁰ (тус хуулийн 80 дугаар зүйл). Тус хуулиар хорих газар ял эдэлж буй 30 хүртлэх насны ангилалд багтах ялтанд анхан ба бүрэн дунд шатны ерөнхий боловсрол, харин 30 дээш насны болон тахир дутуугийн I, II групптэй ялтанд тэдгээрийн санал, хүсэлтийг үндэслэн тус тус эзэмшүүлэхээр зохицуулсан²¹. Бүх насаараа хорих ялаар шийтгүүлсэн ялтны хувьд бие даан суралцах хэлбэрээр боловсрол эзэмших боломж нөхцлийг бүрдүүлжээ.

Ерөнхий боловсролоос гадна хорих байгууллагын зүгээс, ямар нэгэн мэргэжил эзэмшээгүй ялтанд мэргэжлийн боловсрол олгох чиглэлээр шат шатны сургалтыг зохион байгуулж, төгсөгчдөд мэргэжлийн үнэмлэх олгох ажлыг зохион байгуулна.Тус улсын хуулиар хорих байгууллагад ял эдэлж буй ялтанд

¹⁹“Конституция Российской Федерации” (принята всенародным голосованием 12.12.1993) (от 21.07.2014 N 11-ФКЗ).

²⁰ Федеральный закон "Об образовании в Российской Федерации" от 29.12.2012 N 273-ФЗ.

²¹ "Уголовно-исполнительный кодекс Российской Федерации" от 08.01.1997 N 1-ФЗ.

мэргэжлийн дунд болон дээд боловсролыг эчнээ ба зайны сургалт хэлбэрээр эзэмшүүлэхийг зөвшөөрсөн.

Хорих ялаар шийтгүүлсэн ялтны боловсрол болон мэргэжил эзэмших эрхийг хангах зорилгоор засан хүмүүжүүлэх колони тус улсын Хууль зүйн яамтай зөвшилцсөний үндсэн дээр ОХУ-ын гүйцэтгэх засаглалын байгууллагын санаачлагаар оройн сургууль, сургалтын талаар зөвлөгөө өгөх цэг зэргийг байгуулан ажиллаж байна. Гэхдээ тухайн засан хүмүүжүүлэх колониос 80-аас доошгүй ялтан суралцах боломжтой тохиолдолд эдгээр сургууль болон цэгийг байгуулна.

2018 оны жилийн эцсийн статистик мэдээгээр тус улсын засан хүмүүжүүлэх колоний харьяа боловсролын байгууллагад ойролцоогоор 60000 гаруй ялтан суралцсанаас 64 хувь нь 5-9 дүгээр анги, 29 хувь нь 10 дугаар анги, 7 хувь нь анхан шатны буюу бага ангид суралцсан байна.

Хорих байгууллагын харьяа үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагын багш, ажилтныг гол төлөв тухайн салбарт алба хааж байсан офицер, ахлагч болон ажилтан нараас сонгон авдаг байна.

ОХУ-д хорих ялаар шийтгүүлсэн ялтан дараах их сургуульд сурч мэргэжлийн дээд боловсрол эзэмших боломжтой. Үүнд:

- Псковын улсын их сургууль
- Тверийн хөдөө аж ахуйн академи
- ОХУ-ын нийгмийн ухааны их сургууль
- Москвагийн физик-инженерийн институт
- Москвагийн нийгмийн их сургууль
- Владивостокийн эдийн засаг, нийтийн ахуйн үйлчилгээний их сургууль
- Уралын нийгмийн боловсролын их сургууль
- Донын улсын их сургууль
- Челябинскийн улсын их сургууль
- Амурын улсын их сургууль
- Дорнод Европын Олон улсын их сургууль
- Саратовын нийгэм, эдийн засгийн их сургууль
- ОХУ-ын санхүү, эдийн засгийн институт
- “Их сургуулиудын нээлттэй олон улсын бүлэг” ТББ
- “Боловсрол болон бие бялдрын хөгжлийг зохицуулах төв” байгууллага Организация "Центр координации образования и физического развития"
- Бусад.

Үүнээс гадна АНУ-ын New York University, ОХУ-ын Балтийн сургалтын төв, Хүмүүнлэгийн академи зэрэг олон улсын болон үндэсний сургалт, мэргэжлийн байгууллагуудтай чиглэлд хамтран ажилладаг²².

Хорих ялаар шийтгүүлсэн ялтны хувьд ял эдэлж буй байгууллагын оршин байгаа болон хамтран ажилладаг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгох мэргэжил байхгүй тохиолдолд, Холбооны ял эдлүүлэх ерөнхий газарт албан ёсны хүсэлт гарган өөр их, дээд сургуульд төлбөртэйгээр суралцах эрхтэй.

Тус улсын Холбооны ял эдлүүлэх ерөнхий газар эдгээр сургалтын байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хорих ялаар шийтгүүлсэн ялтныг сургаж, төгсгөгчдөд мэргэжлийн дээд боловсролын гэрчилгээ олгодог байна.

²²Строева Г. В. Интеллектуально-этическое развитие личности осужденного // Педагогический журнал- 2012-№1-С.129–153.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөөд 2 жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд эрх зүйн хийдэлтэй зохицуулалт болон маргаан дагуулж буй заалтуудыг хэрхэн засаж, сайжруулах талаар олон талын сургалт, хэлэлцүүлэг, судалгаанууд хийгдсээр байгаа билээ.

Энэ хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал профессорын судалгааны багийн судлаачдаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хорих ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой дэглэм, зэрэглэл болон нийгэмшүүлэх ажлын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дараах дүгнэлт, зөвлөмжид хүрч байна.

4.1.Дүгнэлт

1.Монгол Улсад хорих ял эдлүүлэх дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудал анх 2006 оноос хойш холбогдох удирдлага, зохион байгуулалтын шинжтэй болон 5 удаагийн судалгаа, шинжилгээний ажил хийгдэн, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад нээлттэй, хаалттай хорих ангийн энгийн болон тусгай зэрэглэл, тусгай нэгжийн талаар тусгагдсан байна.

Бараг 60 гаруй жил хэрэгжиж ирсэн жирийн, чанга, онцгой дэглэм болон гянданг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудал харьцангуй онолын болон практик хэрэгжилтийн хувьд хүндрэлтэй байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшүүлэх үндсэн гол арга нь хорих ял эдлүүлэх дэглэмийн оновчтой тогтолцоо, түүнд тохирсон нөхцөл журмыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байдаг ба өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нээлттэй, хаалттай дэглэм нь хоорондоо хоригдлын уулзалт зэрэг зарим нэг нөхцөлөөр л ялгагдаж байна. Түүнчлэн нээлттэй, хаалттай гэсэн тогтолцоо нь хуульд дэглэм гэж нарийвчлан хуульчлагдаагүй байна.

Зүй нь дэглэм нь ял эдлэх нөхцөлийн ялгаатай байдал гэж үзвэл хорих орчин нөхцөл, хамгаалалт, нийгэмшүүлэх ажилд хамрагдах байдал, уулзалт, эрхийн хязгаарлалт, хөдөлмөрийн нөхцөл зэрэг олон зүйлээр ялгагдаж байх ёстой байна.

2.Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн практикт хорих ял эдлэгсдийн дунд урьд гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байсан этгээдүүдийн тоо 30-40% байгаа нь хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажил төдийлөн үр нөлөө багатай байгааг харуулж байна.

Хорих ялтай холбоотой нийгэмшүүлэх ажлыг өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

а/хорих ял эдлүүлэх ажиллагааны хүрээнд явагдаж буй нийгэмшүүлэх ажил нь 2017 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218, 219 дүгээр зүйл, 2018 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Нийгмийн ажлын аргачилсан заавар;

б/хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон шийдвэрийг биелүүлэх үеийн хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 185-189 дүгээр зүйл;

в/шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа дуусч суллагдсан этгээдийн хяналтыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 болон 41-45 дүгээр зүйлийн хүрээнд зохицуулж байна.

Дэлхийн ихэнх оронд хоригдолд үзүүлэх нийгэмшүүлэх ажлыг тухайн иргэнийг нийгмийн харилцаанд оролцогч гэдэг утгаар нь дараах үндсэн хэлбэрүүдээр явагдаж байна.

1.Нийгмийн харилцаанд эрх зүйн дэг журмыг мөрддөг, бие даан амьдрах чадвартай иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгдсэн амьдрах ухааны болон боловсрол, мэргэжил, хөдөлмөрийн дадлага олгох “СУРГАЛТ”-ад хамруулах;

2.Тухайн хүний ур чадвар, хүсэл, сонирхлыг харгалзан тогтвортой ажлын байраар хангахад чиглэсэн “ЗУУЧЛАХ” үйлчилгээг явуулах;

3.Суллагдсан хүний хувийн болон санхүү, гэр бүлийн байдал зэргийг харгалзан “НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН” үйлчилгээнд хамруулах зэрэг болно.

Хорих ангид явуулах нийгэмшүүлэх ажил нь өнөөгийн мөрдөгдөж буй хууль тогтоомж, нийгэмшүүлэх ажлын онолын хувьд явуулж буй хэлбэр нь эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх зэрэг зөвхөн “Сургалт”-ын хүрээнд явагддаг болох нь харагдаж байна.

Судалгааны ажлын хүрээнд 8-20 хүртэл жил хорих ял эдлэж буй нийт 476 хоригдлоос сурах хэрэгцээний талаар анкетийн аргаар судалгаа авч дүгнэж үзэхэд 179 нь буюу 37,6 хувь нь мэргэжил эзэмших, 133 нь буюу 17,9 хувь нь боловсрол эзэмших, 48 нь буюу 10,8 хувь гадаад хэл эзэмших хүсэлтэй буюу нийт 70 орчим хувь тодорхой чиглэлийн боловсрол эзэмших хүсэлтэй байгаагаар илэрхийлжээ. Бичиг үсгийн болон суурь боловсролыг тухайн ангилалд хамаарах зорилтот нийт хоригдлуудын дунд явуулахаас гадна, дээд боловсролын сургалтад хамрагдах хоригдлын тоог нэмэгдүүлэх нь хорих ангиас суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр боловсролын байгууллагуудтай бүх талаар хамтран ажиллах нь өнөөгийн нөхцөлд зүй ёсоор шаардагдаж байна.

4.2.Зөвлөмж

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195 дугаар зүйлийг боловсронгуй болгон өөрчлөн, 195.1-ийг “Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай дэглэмтэй хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг /цаашид “хорих анги” гэх/, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ” гэж өөрчлөн найруулан, 198.3, 199.4, 200.4-д заасан зэрэглэл хоорондын ялгааг улам нарийвчлах;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199.1-д “Хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна. Тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна” гэснийг “Хаалттай хорих анги нь энгийн болон тусгай, онцгой зэрэглэлтэй байна. Онцгой зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна” гэж өөрчлөн найруулах;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 201.1-д “Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ” гэснийг “Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын дотоод журмыг Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хамтран батална” гэж өөрчлөн найруулах.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 220.1-д “Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги туслалцаа үзүүлнэ” гэснийг “Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь бичиг үсгийн, ерөнхий боловсролын, мэргэжлийн боловсролын, амьдрах ухааны хөтөлбөрөөр дамжуулан хорих анги сургалтыг зохион байгуулна” гэж өөрчлөн найруулах

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 219.2-д “Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно” гэснийг Хорих ангид зохион байгуулах сургалтад орон нутгийн төрийн болон төрийн бус өмчийн боловсролын байгууллага, иргэнийг оролцуулна гэж өөрчлөн найруулах зэргээр олон асуудлуудыг нарийвчлан судлан зохицуулах шаардлага байна.

ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992. № 1.
- Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. № 7.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. № 24.

Судалгааны тайлан, эмхтгэл

- ШШГЕГ.Хорих ял эдлүүлэх албаны 2015-2019 оны үйл ажиллагааны тайлан.
- ШШГЕГ-ын тоо бүртгэл, судалгааны тасгийн 2015-2019 оны жилийн үйл ажиллагааны тайлан.
- ШШГЕГ-ын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн 2015-2019 оны үйл ажиллагааны тайлан
- ДХИС.Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт /2003-2018/ судалгааны тайлан

Ном, сурах бичиг, гарын авлага

- Б.Дашзэвэг. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй-1. УБ., 2003.
- Б.Дашзэвэг. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй-2. УБ., 2004.
- С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/. УБ., 2014.
- С.Жанцан. Эрүүгийн хариуцлага. УБ., 2006.
- С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/. УБ., 2011.
- А.Лхагва. Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ., 2013.
- А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2012.
- Р.Оюунбадам. Тусгайлсан сургалт, нийгмийн ажлын уламжлал шинэчлэлийн зарим асуудал. УБ., 2005.
- ШШГЕГ. Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2019.
- Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдал. УБ., 2017.

Сэтгүүл

- ШШГС.Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүлийн 2012-2019 оны 4 дүгээр улирал хүртэлх дугаар.

Докторын зэрэг хамгаалсан бүтээл

- Д.Бадам. Насанд хүрээгүй этгээдэд оногдуулах хорих ял: эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2012.
- Р.Оюунбадам. Монгол улс дахь эмэгтэйчүүдийн хорих ял: онол, арга зүй, практик. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2013.
- Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх ажиллагааны онол, арга зүй. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2015.

- Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох нь. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2017.

Интернет сүлжээн дэх веб сайт

- www.cd.gov.mn

ХАВСРАЛТ

Хавсралт 1. 2003-2018 онуудад анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг /аймаг, орон нутгаар/²³

Шүүх	Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо															
	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Архангай	130	160	234	156	146	98	76	87	108	143	159	151	138	117	174	237
Баян-Өлгий	104	84	89	90	87	96	89	62	88	101	76	76	80	73	150	186
Баянхонгор	158	121	113	114	130	155	161	154	170	132	146	195	169	167	259	310
Булган	158	168	172	138	119	108	97	74	124	118	113	116	136	109	174	204
Говь-Алтай	105	108	95	94	77	69	45	64	84	84	75	63	76	47	95	113
Говьсүмбэр	53	56	68	69	63	38	34	46	33	37	53	46	76	75	83	113
Дархан-Уул	318	329	440	356	304	209	259	247	278	229	190	254	285	216	374	461
Дорнод	169	175	199	192	188	169	136	125	120	118	220	221	209	138	233	368
Дорноговь	224	221	236	210	260	222	208	232	179	175	239	196	227	244	383	294
Дундговь	110	116	128	109	110	88	71	68	80	80	89	88	95	50	95	123
Завхан	151	146	143	120	113	95	87	68	52	82	82	91	111	92	121	144
Орхон	182	209	188	168	243	196	167	150	161	167	167	220	239	197	426	406
Өвөрхангай	222	217	260	225	252	160	125	164	182	194	167	174	228	171	260	339
Өмнөговь	146	123	108	93	125	109	116	117	128	144	137	173	218	171	267	342
Сүхбаатар	80	71	92	91	112	143	105	114	110	90	128	133	120	86	166	237
Сэлэнгэ	357	430	497	352	346	358	338	284	279	337	292	349	357	293	444	519
Төв	194	251	207	161	200	222	181	170	213	245	270	168	271	400	447	381

²³ МУДШ.Монголын Шүүх. II боть. 304 дахь тал

Сэлэнгэ	543	637	660	498	517	560	540	389	409	472	387	453	425	355	378	473
Төв	254	383	293	242	295	305	232	215	291	341	343	184	250	291	380	366
Увс	224	257	367	251	213	267	246	195	200	182	125	147	170	155	168	191
Ховд	214	239	219	243	252	253	142	147	151	115	151	106	183	103	198	205
Хөвсгөл	332	375	372	229	236	261	154	138	250	243	210	230	265	219	289	331
Хэнтий	288	310	338	325	281	211	224	191	338	286	232	248	276	156	210	256
Нийслэл	3576	3782	3979	2821	3293	3862	3589	3700	3944	4113	3842	4034	3334	2950	4092	7870

Хавсралт 3.. 2003-2018 онуудад ял шийтгүүлэгчдийн байдал

д/д	Он	Нийт ял шийтгүүлэгчид	Насанд хүрээгүй этгээд	Эмэгтэйчүүд	Урьд ял шийтгүүлсэн	Гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн	Согуугаар гэмт хэрэг үйлдсэн	Ажил, сургуульгүй хүмүүс
1.	2004	9473	1121	735	2065	1818	2228	6977
2.	2005	10153	1195	876	2051	1873	2212	7206
3.	2006	7792	727	660	1801	1403	1726	5240
4.	2007	8463	963	710	1904	1496	1742	4967
5.	2008	8495	547	799	1638	1578	2014	5282
6.	2009	7513	386	656	1637	1314	1610	5047
7.	2010	7292	451	612	1645	1407	1512	4881
8.	2011	8210	542	724	1460	1465	1704	5493
9.	2012	8324	570	726	1544	1498	1717	5471
10.	2013	8065	565	692	2202	1414	1710	4935
11.	2014	8178	492	718	2374	1604	1582	5000
12.	2015	7696	422	664	2500	1616	1700	4840
13.	2016	6566	360	518	2164	1382	1729	4111
14.	2017	9019	425	933	1977	1497	2256	5586
15.	2018	12366	302	1375	2614	967	2947	8520